



Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг
хөгжүүлэх мастер төлөвлөгөөний
мэдээлэл цуглуулах судалгаа

Тайлангийн төсөл

Улаанбаатар хот
2019 оны 2 дугаар сар

Гарчиг

1. Оршил	5
1.1. Судалгааны зорилго.....	5
1.2. Арга зүй, хамрах хүрээ	5
2. Хүнсний ногооны нийлүүлэлт	6
2.1. Төмс, хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл.....	6
2.2. Ногоо тариалдаг өрхүүдийн үйлдвэрлэл	8
2.3. Хүнсний ногооны импорт	9
3. Хүнсний ногооны хэрэглээ	11
3.1. Өрхийн хүнсний ногооны хэрэглээ	11
3.2. Дотоодын хүнсний ногооны талаарх хэрэглэгчдийн хандлага	14
4. Хүнсний ногооны үнэ цэний сүлжээний шинжилгээ	18
4.1. Үнийн шинжилгээ	18
4.1.1. Үйлдвэрлэгчийн үнэ, үйлдвэрлэгчийн нэмэгдэл өртөг	18
4.1.2. Импортын үнэ.....	23
4.1.3. Хэрэглэгчийн үнэ	24
4.1.4. Үйлдвэрлэгчийн ба хэрэглэгчийн үнийн зөрүү.....	26
4.2. Хүнсний ногооны түгээлтийн үе шат	27
4.2.1. Агуулахын үйл ажиллагаа.....	27
4.2.2. Бөөний болон жижиглэн худалдаа	28
4.3. Нийтийн хоолны салбар	32
4.4. Боловсруулсан хүнсний ногооны зах зээл.....	33
5. Хүнсний ногооны салбарын бодлогын тойм.....	37
5.1. Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгт хөтөлбөрүүд.....	37
5.2. Олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд	43
6. Хүнсний ногооны салбарт тулгамдаж буй бэрхшээл	47
6.1. Хүнсний ногоо тариалалтад тулгарч буй бэрхшээл	47
6.2. Агуулахын үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл	49
6.3. Хүнсний ногооны борлуулалтад тулгарч буй бэрхшээл	51
6.4. Нийтийн хоолны салбарт тулгарч буй бэрхшээл	52
7. Дүгнэлт, санал зөвлөмж	54
Ашигласан материал.....	58
Хавсралт.....	59
Түүвэр судалгаанд оролцогчдын жагсаалт.....	59

Товчилсон үгсийн жагсаалт

АХБ	Азийн хөгжлийн банк
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал зуучлалын яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
НОАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ӨНЭЗС	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа
ОХУ	Оросын холбооны улс
ХНХСИ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХААҮТП	Хөдөө аж ахуйн үйлдвэр, технологийн парк
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭЗСЭШХ	Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

Зураг хүснэгтийн жагсаалт

Зураг 1. Тариалалтын талбай, мянган га.....	6
Зураг 2. Нийт хураасан ургац, мянган тонн	7
Зураг 3. Хүнсний ногооны тариалалт, мянган тонн	8
Зураг 4. Ногоо тарьдаг өрхүүдийн ногооны тариалалт, %	8
Зураг 5. Өрхийн төмс, хүнсний ногооны нийт хэрэглээ	11
Зураг 6. Өрхийн хүнсний ногооны худалдан авалт, ногоо тус бүрийн зардлын эзлэх жин, 2017.....	12
Зураг 7. Өрхийн гол хүнсний ногооны сарын хэрэглээ (кг), улирлаар, кг	12
Зураг 8. Өрхийн гол хүнсний ногооны сарын хэрэглээ (кг), суурьшлаар	13
Зураг 9. Өрхийн бусад хүнсний ногооны сарын хэрэглээ (кг), улирлаар	13
Зураг 10. Өрхийн бусад хүнсний ногооны сарын хэрэглээ (кг), суурьшлаар	14
Зураг 11. Хамгийн их эрэлттэй дотоодын хүнсний ногоо, давтамж.....	15
Зураг 12. Хэрэглэгчдийн дотоодын хүнсний ногоо худалдан авахдаа чухалчилдаг шинж, давтамж	15
Зураг 13. Рестораны хамгийн их ашигладаг дотоодын хүнсний ногоо, давтамж	16
Зураг 14. Рестораны хүнсний ногооны хэрэглээний бүтэц, дунджаар	16
Зураг 15. Рестораны хүнсний ногоог худалдан авахдаа чухалчилдаг шинж, давтамж ..	17
Зураг 16. Хүнсний ногоо тариалах зардлын бүтэц	20
Зураг 17. Импортын гол нэрийн хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг/кг	23
Зураг 18. Гол хүнсний ногооны үнэ (төгрөг/кг), улирлаар	24
Зураг 19. Гол хүнсний ногооны үнэ (төгрөг/кг), байршлаар	25
Зураг 20. Бусад хүнсний ногооны үнэ (төгрөг/кг), улирлаар	25
Зураг 21. Бусад хүнсний ногооны үнэ (төгрөг/кг), байршлаар	26
Зураг 22. Агуулах дахь ногооноос дотоодын хүнсний ногооны эзлэх хувь	28
Зураг 23. Зах, супермаркетад худалдаалж буй хүнсний ногооны бүтэц, дунджаар.....	29
Зураг 24. Зах, супермаркетад худалдаалж буй хүнсний ногооны үнийн нэмэгдэл хувь, дунджаар	30
Зураг 25. Зах, супермаркетуудын хүнсний ногоо худалдан авдаг нийлүүлэгч, давтамж	30
Зураг 26. Лаазалсан хүнсний ногооны импорт, мянган ам.доллар	33

Зураг 27. Лаазалснаас бусад боловсруулсан хүнсний ногооны импорт, мянган ам.доллар	34
Зураг 28. Боловсруулсан хүнсний ногооны өрхийн хэрэглээ, 2015-2017 он	35
Зураг 29. Бүтээгдэхүүний үнэ цэнийг дээшлүүлэхэд шаардлагатай алхам, давтамж	42
Зураг 30. ХАА, хүнсний ногооны тариалалтыг дэмжихэд шаардлагатай зүйлс, давтамж	42
Зураг 31. Тариалангийн бизнесээ өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, давтамж	47
Зураг 32. Дотоодын хүнсний ногоог худалдан авахад тулгардаг нийтлэг бэрхшээл, давтамж	51
Зураг 33. Дотоодын хүнсний ногоог борлуулахад тулгардаг нийтлэг бэрхшээл, давтамж	51
Зураг 34. Худалдан авч буй хүнсний ногооны гарал үүслийн тодорхой байдал	53

Хүснэгт 1. Өрхийн хүнсний ногооны нийт ургац, тонн	9
Хүснэгт 2. Хүнсний ногооны импортын хэмжээ (мянган тонн) ба нийт үнийн дүн (мянган ам.доллар)	10
Хүснэгт 3. Дотоодод тарьсан хүнсний ногооны өртгийн сүлжээнд нэмж буй өртгийн хувь	18
Хүснэгт 4. Хүнсний ногооны үйлдвэрлэгчийн дундаж үнэ, төгрөг/кг	19
Хүснэгт 5. Өрхийн дундаж тариалалт ба борлуулалт	19
Хүснэгт 6. Зарим хүнсний ногооны өртгийн шинжилгээ, Ховд аймгийн Буянт сум, 2014 он	21
Хүснэгт 7. Хүлэмж, трактор, агуулах ашиглалт	22
Хүснэгт 8. Хүнсний ногооны үйлдвэрлэгчийн ба импортлогчийн дундаж үнэ (төгрөг/кг), 2017	24
Хүснэгт 9. Хүнсний ногооны үйлдвэрлэгчийн ба хэрэглэгчийн дундаж үнэ (төгрөг/кг), 2017	26
Хүснэгт 10. Зах, супермаркетад худалдаалж буй хүнсний ногооны үнэ, дунджаар, төгрөг/кг	29
Хүснэгт 11. Боловсруулсан хүнсний ногооны өрхийн сарын зардал, суурьшил ба улирлаар, 2017 он	35
Хүснэгт 12. Төмс, хүнсний ногоо тариалалтын өнөөгийн нөхцөл байдал ба “Хүнсний ногоо” хөтөлбөрийн зорилт	38

1. Оршил

Монголын хөдөө аж ахуй цаашид өсөх боломж ихтэй, эдийн засаг болон хүн амын амьжиргаанд чухал нөлөөтэй салбар боловч хөгжлийн хувьд хоцрогдонгүй салбар юм. Төрөөс уул уурхайгаас бусад салбарыг төрөлжүүлэн хөгжүүлэх бодлогын хүрээнд хөдөө аж ахуйн салбар нь эдийн засгийн өсөлт, хөгжлийн тэргүүлэх салбарын нэг болоод байна. Монголын хүнсний ногооны салбар сүүлийн жилүүдэд тэлж, төмсний дотоодын хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд хүрч байгаа боловч хүнсний ногооны салбар ерөнхийдөө дотоодын бололцоогоо бүрэн ашиглаж чадахгүй, улмаар дотоодын хэрэгцээг хангаж чадахгүй байна. Дотоодын хүнсний ногооны салбар хангалттай хэмжээнд хөгжиж чадаагүйгээс хүн амын хүнсний ногооны хэрэглээг импортоор хангаж байгаа нь хүнсний ногоо тариаланчдын орлогыг бууруулж, цаашлаад хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөөлөх сул талтай юм.

1.1. Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын хүнсний ногооны салбарын үйлдвэрлэл, түгээлт, борлуулалтын өнөөгийн байдал, хүндрэлүүдийг тодруулах, үүнд үндэслэн санал зөвлөмж дэвшүүлэхэд оршино. Судалгаа нь хүнсний ногооны салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах, уг сүлжээг дэмжих үр дүнтэй бодлого боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангана гэж найдаж байна.

1.2. Арга зүй, хамрах хүрээ

Судалгааны баг эхлээд дотоодын хүнсний ногооны зах зээлийн нөхцөл байдлын талаарх хоёрдогч эх үүсвэрийн мэдээлэл цуглуулж, шинжилгээ хийсэн. Тодруулбал, жил тутмын хураасан ургац, сар бүрийн импортын мэдээлэл, өрхийн хүнсний ногооны аж ахуйн тариалалт, хэрэглээ зэрэг тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үүнээс гадна хүнсний ногооны салбарын тариалалтад ашиглагддаг машин, тоног төхөөрөмж, техник, технологи, борлуулалтын системийн онцлог, энэ талаар Засгийн газрын баримталж буй бодлого, дэмжлэгийн өнөөгийн байдалд чанарын шинжилгээ хийсэн. Эдгээр мэдээллийг Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар, ХХААХҮЯ болон холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага зэрэг эх үүсвэрээс цуглуулж, шинжилгээ хийсэн.

Түүвэр судалгааны хүрээнд нийт 65 оролцогчоос дунджаар 30-60 орчим минут үргэлжлэх ярилцлага хийж, мэдээлэл цуглуулсан. Судалгааны асуулгуудыг Хавсралт хэсэгт оруулав. Бодлого боловсруулах шатны ХХААХҮЯ, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв, Үндэсний хөгжлийн газар болон сонгогдсон хоёр аймаг, хоёр сумаас хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн тус бүр нэг албан хаагчийг судалгаанд хамрууллаа. Албаны хүмүүсээс гадна Булган болон Сэлэнгэ аймгийн тариаланчдаас ярилцлагын судалгаа авсан. Судалгааны зорилтот бүлэгт Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд мөн багтсан. Хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдын төлөөллийг хангахын тулд тус хотуудад үйл ажиллагаа явуулж буй супермаркет, зах, ресторан, зочид буудал, агуулахуудыг судалгаанд хамруулсан.


Судалгааны баг дээрх оролцогчдоос авсан мэдээлэл болон суурь тоон өгөгдлийн шинжилгээнд тулгуурлан Монголын хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээний ерөнхий дүр зураг, тулгарч буй асуудал, хүндрэлүүдийг тодорхойлохыг зорилоо. Мөн хүнсний ногооны салбарт хэрэгжиж буй Засгийн газрын бодлого болон олон улсын байгууллага, орон нутгийн дэмжлэгт хөтөлбөрүүдийн зорилт, хэрэгжилт болон түүвэр судалгааны үр дүнг нэгтгэн шинжилж цаашдын төсөл, хөтөлбөр боловсруулахад анхаарах асуудлуудын талаар санал зөвлөмж дэвшүүлээ.

2. Хүнсний ногооны нийлүүлэлт

2.1. Төмс, хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл

Монгол улс нийт төмс болон лууван, байцаа, шар манжин, улаан манжин, сонгино, саримс, улаан лооль, тарвас зэрэг 9 төрлийн хүнсний ногоог голчлон дотооддоо тариалж байна. 2017 оны байдлаар улсын нийт дүнгээр 14.6 мянган га талбайд төмс, 7.7 мянган га талбайд хүнсний ногоо тариалжээ. Аж ахуйн нэгжүүд нийт төмс тариалсан талбайн 4.8 мянган га буюу 33%-д, нийт хүнсний ногоо тариалсан талбайн 1.8 мянган га буюу 23.4%-д тариалалт хийсэн бол бусад талбайд өрхүүд төмс, хүнсний ногоо тариалсан. Дотоодын төмс, хүнсний ногооны тариалалтад өрхийн аж ахуй илүү давамгайлж байна.

Зураг 1. Тариалалтын талбай, мянган га




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2018 онд аж ахуйн нэгж болон өрхүүд нийт 169 мянган тонн төмс, 101 мянган тонн хүнсний ногооны ургац хураажээ. Сүүлийн жилүүдэд хүн амын тоо болон нэг хүнд ноогдох хэрэглээ нэмэгдэхийн хэрээр дотоодын төмс, хүнсний ногооны эрэлт өсөж байгаа ч дотоодын хүнсний ногооны нийлүүлэлт буюу тариалалт төдийлөн өсөөгүй байна. 2017 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар нэг хүний өдрийн хүнсний ногооны хэрэглээний жишгийг 200 грамм байсныг 260 грамм болгож өсгөсөн. Хөдөө, орон нутгийн иргэд, малчдад шинэ ургацын ногоо, үйлдвэрийн аргаар боловсруулсан ногоог

хүргэх худалдаа, үйлчилгээ, хадгалалтын сүлжээ байхгүйгээс хөдөөгийн хүн амын хүнсний ногооны хэрэглээ хангалтгүй байсаар байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэл нь гар ажиллагаа ихтэй, нарийн технологитой, шинэ технологи нэвтрүүлэхэд өртөг өндөртэй байдаг. 2017 оны байдлаар хүнсний ногооны механикжуулсан түвшин 38% байсан бөгөөд тариалан эрхлэгчдийн 96.5% нь талбайгаа энгийн аргаар, дөнгөж 3.5% нь инженерийн системтэй услалтын системээр усалж байна. Түүнчлэн хүнсний ногооны нийт үйлдвэрлэлд эзлэх хамгаалагдсан хөрсний аж ахуйн үйлдвэрлэл 6% хүрэхгүй байна.


Зураг 2. Нийт хураасан ургац, мянган тонн



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монголд цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан тариалалтын хугацаа харьцангуй богино байдаг. Хүнсний ногооноос лууван, шар манжин, байцай, сонгино голчлон тариалж байна. Өөрөөр хэлбэл, хадгалалт болон тариалалтын хамгийн энгийн технологи шаардагдах хүнсний ногоог голчлон тариалж байна. Харин хүлэмжид тариалдаг, эсвэл тариалалтын тусгай орчин, нарийн технологи шаарддаг хүнсний ногооны тариалалт бага байна. Түүнчлэн, цаг агаарын нөхцөл таагүй үед дотоодын ургац буурдаг. Тухайлбал, 2017 оны зун тохиосон гангаас шалтгаалан 2016 онтой ижил хэмжээний талбайд төмс тариалсан ч хураан авсан ургацын хэмжээ 121.8 тонн буюу 2016 оны түвшнээс 26%-аар буурсан.

Зураг 3. Хүнсний ногооны тариалалт, мянган тонн




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2.2. Ногоо тариалдаг өрхүүдийн үйлдвэрлэл

ҮСХ-ны 2017 оны Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны (ӨНЭЗС) үр дүнг ерөнхийлөн тархааж тооцоход, улсын хэмжээгээр нийт өрхийн 1.92% буюу 16,883 өрх төмс, хүнсний ногоо тариалжээ. Эдгээр өрхийн тарьдаг ногооны бүтэц, ашиглалтыг дараах зурагт харуулав.

Зураг 4. Ногоо тарьдаг өрхүүдийн ногооны тариалалт, %



Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС 2017 болон судалгааны багийн тооцоолол

Ногоо тариалдаг өрхүүдийн 90% нь төмс тариалдаг бол лууван, манжинг өрхүүдийн талаас илүү нь тариалж байна. Харин ҮСХ-ны 2015 онд гүйцэтгэсэн ХАА-н түүвэр судалгаанд дурдсанаар, тухайн онд төмс тариалдаг өрхийн тоо 14,363 ба хүнсний ногоо тариалдаг өрхийн тоо 12,549 байжээ. Иймээс дээр дурдсан 2017 оны өрхийн түүвэр судалгааны дүн болон 2015 онд гүйцэтгэсэн ХАА-н түүвэр судалгааны дүнгүүд хоорондоо нийцтэй гэж үзэж болно.

Өрхүүдийн дийлэнх нь жижиг хэмжээний тариалан эрхэлж зөвхөн өрхийн хэрэгцээндээ зориулж ногоо тариалдаг. Тухайлбал, төмс тариалдаг өрхүүдийн 62.3% хураасан ургацаа

зөвхөн өрхийн хэрэгцээнд зориулдаг бол бусад хүнсний ногооны хувьд энэ үзүүлэлт 60% - 80% хүрдэг. Худалдах зорилгоор хүнсний ногоо тариалдаг өрхүүдийн тоо цөөн боловч ихэвчлэн том талбайд их хэмжээгээр тариалдаг. Ногоо тарьдаг өрхүүдийн нийт хураасан ургацын хэмжээ болон ашиглалтыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Өрхийн хүнсний ногооны нийт ургац, тонн

Ногоо	Хураасан нийт ургац	Үүнээс:							
		Өрхийн хэрэгцээнд		Малын тэжээлд		Худалдсан		Бусдад өгсөн, хадгалсан	
		Тоо	Хувийн жин, %	Тоо	Хувийн жин, %	Тоо	Хувийн жин, %	Тоо	Хувийн жин, %
Төмс	50,400	4,392	9	3,247	6	32,700	65	10,061	20
Лууван	12,200	810	7	373	3	9,734	80	1,283	11
Манжин	2,763	362	13	274	10	1,971	71	157	6
Байцай	2,754	475	17	34	1	2,213	80	32	1
Сонгино	723	323	45	3	0	320	44	77	11
Саримс	8	4	50	0	0	1	13	4	50
Улаан лооль	709	179	25	0	0	528	74	2	0
Өргөст хэмх	1,168	331	28	1	0	797	68	38	3

Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС 2017 болон судалгааны багийн тооцоолол

Хүнсний ногоо тариалдаг өрхүүдийн жилийн борлуулалтын орлого 1,517,000 төгрөг байсан бол зарлага нь 685,000 төгрөг байжээ.

2.3. Хүнсний ногооны импорт

Монгол Улс дотоодын хүнсний ногооны нийлүүлэлтээс давсан эрэлтийг импортын хүнсний ногоогоор хангадаг. Хүн амын тоо болон хэрэглээ нэмэгдэхийн хэрээр импортоор оруулж ирж буй хүнсний ногооны хэмжээ өсөж байна. ҮСХ болон ГЕГ-ын статистик мэдээллээс харахад, 2018 оны байдлаар Монгол Улсын нийт сонгино саримсны нийлүүлэлтийн 66%, байцайны эрэлтийн 60%, лууван, манжингийн 21% гаруй, өргөст хэмхийн 30%, улаан лоолийн 20% орчим нь импортын хүнсний ногоо байна.

2018 оны байдлаар манай улс нийт 100.5 мянган тонн хүнсний ногоо буюу 15.7 сая ам.доллартой тэнцэх хүнсний ногоо импортолжээ. Үүнээс 28.2%-ийг байцай (28.3 мянган тонн), 28%-ийг сонгино, саримс (28.1 тонн), 9.6%-ийг лууван, манжин бүрдүүлж байна. Эдгээр хүнсний ногоо нь дотоодын хүнсний ногооны тариалалтад мөн дийлэнх хувийг эзэлдэг хэдий ч дотоодын эрэлтийг хангах түвшинд хүрээгүй байна. Жил бүрийн

хүнсний ногооны импортын дийлэнх буюу 90% гаруйг БНХАУ-аас импортолж байна. ОХУ-д 30 хүртэлх хоногоор визгүй зорчдог болсонтой холбоотойгоор сүүлийн жилүүдэд ОХУ-аас хийх хүнсний ногооны импорт нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 2. Хүнсний ногооны импортын хэмжээ (мянган тонн) ба нийт үнийн дүн (мянган ам.доллар)

	2014		2015		2016		2017		2018	
	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
Төмс	-	1,008	17.1	3,468	0.7	215	0.4	110	2.9	568
Улаан лооль	4.1	1,138	3.9	942	1.7	422	0.7	192	0.8	230
Сонгино, саримс	19.1	3,585	8.6	2,227	12.4	2,714	17.4	3,694	28.1	4,743
Байцай	23.9	4,425	24.5	4,603	24.6	4,885	30.0	5,536	28.3	5,743
Лууван, манжин, бусад үндэс үрт ногоо	9.1	1,483	2.3	518	8.6	1,596	9.9	1,811	9.6	1,683
Өргөст хэмх	3.0	826	3.3	777	1.8	435	0.7	169	0.8	210
Буурцагт ургамал	0.1	26	0.1	19	0.1	55	0.0	2	0.0	6
Бусад ногоо	6.2	1,813	6.9	1,697	5.5	1,353	15.2	3,271	14.9	3,370
Нийт	71.6	14,304	73.5	10,784	61.0	11,459	89.7	14,676	100.5	15,673

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монголд зөвхөн зуны улиралд тариалан явуулдаг төдийгүй зориулалтын агуулах, хүлэмжийн дутмаг байдлаас шалтгаалан нарийн болон навчит ногоо бага тариалж байна. Өргөст хэмх, улаан лооль, чинжүү, навчит ногоо зэрэг голлох нэрийн хүнсний нарийн ногоог импортоор авч байна.


Энэ судалгааны явцад хийсэн түүвэр ярилцлагуудаас харахад, хэрэглэгчид импортын хүнсний ногооноос илүү дотоодын хүнсний ногоог өндөр үнэтэй байсан ч илүү хэрэглэх хандлагатай байна (Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг хавсралтаас харна уу). Тухайлбал, судалгаанд хамрагдсан зах, супермаркет, ресторан, агуулахын бизнес эрхлэгч 43 хүнээс 36 нь буюу 84% нь хэрэглэгчид үнээс үл хамааран дотоодын хүнсний ногоог худалдаж авдаг, 5 нь үнэ боломжийн үед дотоодын хүнсний ногоог худалдаж авдаг гэж хариулсан бол 2 оролцогч чанарын хувьд дотоодын хүнсний ногоо үргэлж сайн байдаг тул худалдан авдаг гэж дүгнэжээ.

3. Хүнсний ногооны хэрэглээ

3.1. Өрхийн хүнсний ногооны хэрэглээ

ҮСХ-ны өрхийн судалгааны мэдээлэлд хийсэн шинжилгээгээр, Монголын нийт өрх жилд 120 мянга тонн орчим төмс, хүнсний ногоо хэрэглэж байна. Үүнийхээ 2%-ийг өрхүүд өөрсдийн ногооны талбайгаас хурааж хэрэглэдэг ба үлдсэн 98%-ийг зах зээлээс худалдан авч хэрэглэдэг ажээ. Өрхүүдийн хүнсний ногоонд зарцуулж буй зардал жилдээ 150 гаруй тэрбум төгрөг хүрдэг. Хүнсний ногооны хэрэглээ өрхийн орлогоос шууд хамаарч өөрчлөгддөг. Эдийн засгийн өсөлт удааширч өрхийн орлого буурсан 2016 онд хүнсний ногооны хэрэглээ буурч байжээ. 2015-2017 оны нийт өрхийн хүнсний ногооны хэрэглээний мэдээллийг дараах зурагт харуулав.

Зураг 5. Өрхийн төмс, хүнсний ногооны нийт хэрэглээ




Эх сурвалж: ҮСХ, судлаачдын тооцоолол

2015-2017 оны дунджаар нэг өрх сард 11.4 кг төмс, хүнсний ногоо хэрэглэж, үүнд 14'750 төгрөг зарцуулж байна. Энэ зардал нь өрхийн сарын нийт хүнсний зарлагын дөнгөж 6.5%-ийг л эзэлдэг.

Хүнсний ногоонууд дунд хамгийн их хэрэглээтэй нь төмс бөгөөд төмсний нийт хэрэгцээний 75%-ийг хүн амын хүнсний хэрэгцээ, 23%-ийг үрийн төмсний, 2%-ийг тус улсад амьдарч байгаа гадаадын иргэд болон жуулчид бүрдүүлж байна (NSO, 2016). Үүнээс, хүн амын төмсний хэрэгцээний ойролцоогоор тал хувийг өрхүүд, үлдсэн талыг нийтийн хоолны салбар бүрдүүлж байна.

Хүнсний ногоо худалдан авах нийт зардалд хүнсний ногоо тус бүрийн эзлэх хувийг дараах зурагт харуулав. 2017 оны байдлаар өрхүүд төмс, сонгино, байцай, лууванг хамгийн их худалдан авах хандлагатай байна.

Зураг 6. Өрхийн хүнсний ногооны худалдан авалт, ногоо тус бүрийн зардлын эзлэх жин, 2017




Эх сурвалж: YCX, судлаачдын тооцоолол

Үүнийг 2015 оны худалдан авалттай харьцуулахад төмсний эзлэх жин 6 нэгж хувь, улаан лоолийнх 0.2 нэгж хувь, өргөст хэмхийнх 0.4 нэгж хувиар тус тус буурсан бол бусад хүнсний ногооны эзлэх хувиуд тус бүрдээ 1.6 нэгж хувиар өссөн байна. Энэ нь өрхүүдийн төмсний хэрэглээ буурч бусад ногооны хэрэглээ өссөнтэй холбоогүй, харин бусад ногооны үнэ буураагүй байхад төмсний үнэ хоёр жилийн өмнөх үетэй харьцуулахад ихээхэн буурсантай холбоотой. Үүнийг дараах үр дүнгүүд харуулж байна.

Өрхүүд төмс, сонгино, байцай, лууван гэсэн дөрвөн төрлийн хүнсний ногоог жилийн турш хамгийн их хэрэглэж байна. Тухайлбал, өрхүүд сард дунджаар 6 кг орчим төмс хэрэглэдэг бөгөөд хэрэглээ нь улирлаас бага зэрэг хамаарч, намар ургац хураасны дараа 6.2 кг, бусад улиралд 5.9 кг болдог ажээ. Харин сонгино, луувангийн хэрэглээ улирлаас хамаарч хэлбэлзэх нь маш бага бөгөөд өрхүүд сард тус бүрээс 1.5 кг хэрэглэж байна. Байцайны хэрэглээ III, IV улиралд бага зэрэг нэмэгддэг бөгөөд өрхийн сарын дундаж хэрэглээ улирлаас хамаараад 1.2 – 1.8 кг байна.

Зураг 7. Өрхийн гол хүнсний ногооны сарын хэрэглээ (кг), улирлаар, кг




Эх сурвалж: YCX, судлаачдын тооцоолол

Энэ гол дөрвөн ногооны сарын дундаж хэрэглээг өрхийн суурьшлын бүлгээр тодруулбал, Улаанбаатарын өрхүүд сонгино, байцай, лууванг бусад өрхөөс илүү

хэрэглэх хандлагатай байна. Харин сумын төвийн өрхүүд төмсийг бусад өрхөөс илүү хэрэглэж байна. Ерөнхийдөө хүнсний ногоог Улаанбаатарын өрхүүд хамгийн их, хөдөөгийн өрхүүд, тэр дундаа, малчин өрхүүд хамгийн бага хэрэглэж байна. Тухайлбал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны судалгаагаар, малчин өрхүүдийн 60% хүнсэндээ төмс, 57% нь сонгино, саримс хэрэглэдэг бөгөөд бусад ногоо хэрэглэдэг өрх гуравны нэг хувь ч хүрдэггүй ажээ (ХНХСИ, 2018). Энэ нь, нэг талаас, хот хөдөөгийн өрхүүдийн хоол хүнсэндээ ногоо хэрэглэх дадал хандлага ихээхэн ялгаатай байдгийн илрэл боловч, нөгөө талаас, хүнсний ногооны зах зээлийн хүртээмж хөдөөд муу байдагтай холбоотой юм.


Зураг 8. Өрхийн гол хүнсний ногооны сарын хэрэглээ (кг), суурьшлаар



Эх сурвалж: УСХ, судлаачдын тооцоолол

Бусад хүнсний ногооны хувьд хэрэглээ харьцангуй бага, улирлаас ихээхэн хамаардаг. Улаан лооль, өргөст хэмх зэрэг нарийн ногооны хэрэглээ III улиралд шинэ ургацын нийлүүлэлт нэмэгдсэн үед огцом өсдөг боловч жилийн бусад улиралд эрс буурдаг байна. Жишээлбэл, III улиралд өргөст хэмхийн сарын хэрэглээ 300 гр, улаан лоолийн хэрэглээ 170 гр хүрдэг бол бусад улиралд өргөст хэмхийнх дөнгөж 140-200 гр, улаан лоолийнх 50-100 гр хүрдэг. Харин өрхийн чинжүүний хэрэглээ улирлаас хамаарах нь бага, хэмжээний хувьд ч сард 200 гр хүрэхгүй бага байна. Сүүлийн жилүүдэд манжингийн тариалалт болон хэрэглээ эрс буурч, өрхүүд сард 500 гр ч хүрэхгүйг хэрэглэдэг болжээ.


Зураг 9. Өрхийн бусад хүнсний ногооны сарын хэрэглээ (кг), улирлаар



Эх сурвалж: УСХ, судлаачдын тооцоолол

Бусад хүнсний ногооны сарын дундаж хэрэглээг өрхийн суурьшлын бүлгээр тодруулбал, манжинг аймгийн төвийн өрхүүд илүү их хэрэглэж байна. Улаанбаатарын өрхүүд улаан лооль, өргөст хэмх, чинжүү зэрэг нарийн ногоог бусад өрхөөс илүү хэрэглэдэг бол сумын төвийн болон хөдөөгийн өрхүүд эдгээр ногоог хамгийн бага хэрэглэж байна. Энэ нь, нэг талаас, нарийн ногоо тариалалт маш бага, үнэ өндөр байдагтай холбоотой боловч, нөгөө талаас, нарийн ногооны хүргэлт, хадгалалтын нөхцөлөөс үүдэн зах зээлийн хүртээмж хөдөө орон нутагт муу байдагтай холбоотой.

Зураг 10. Өрхийн бусад хүнсний ногооны сарын хэрэглээ (кг), суурьшлаар



Эх сурвалж: ҮСХ, судлаачдын тооцоолол


Саримсны хэрэглээ ерөнхийдөө бага боловч улирлаас ихээхэн хамаардаг. Хүйтний улиралд ханиад томуунаас сэргийлэх зорилгоор сард 50-60 гр саримс дунджаар хэрэглэдэг бол дулааны улиралд сард дунджаар 20-30 гр-ыг хэрэглэдэг. Бусад ногооны адил, Улаанбаатарын өрхүүд саримсыг хамгийн их (сард дунджаар 40-50 гр) хэрэглэж байхад сумын төвийн болон хөдөөгийн өрх хамгийн бага (сард дунджаар 20-30 гр) хэрэглэж байна.

3.2. Дотоодын хүнсний ногооны талаарх хэрэглэгчдийн хандлага

Энэ судалгааны хүрээнд хүнсний ногоо хэрэглэгчдийн хандлагыг тодорхойлох үүднээс Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын зах, супермаркет, агуулахын 25 бизнес эрхлэгчтэй ярилцлага хийж, тэдний бодлоор хэрэглэгчид **дотоодын** хүнсний ногооны талаар ямар хандлагатай байгааг асууж тодруулсан.

Төмс, лууван, сонгино нь хэрэглэгчдийн хамгийн эрэлттэй хүнсний ногоонууд юм. Судалгаанд оролцсон аж ахуй нэгжүүдийн 96% нь төмсийг, 68% нь лууван, сонгиныг хамгийн эрэлттэй хүнсний ногоо гэж үзсэн. Харин шар манжингийн эрэлт бусад ногоотой харьцуулахад хамгийн бага байсан. Мөн нарийн ногоо болох өргөст хэмх, улаан лоолийн эрэлт бусад хүнсний ногоотой харьцуулахад бага байна. Энэ хандлага нь шар манжингаас бусад ногооны хувьд өмнөх хэсэгт (Зураг 6) танилцуулсан шинжилгээний үр дүнтэй ойролцоо байна. Шар манжингийн хувьд үр дүн зөрүүтэй байгаа нь хотын өрхүүдтэй харьцуулахад хөдөөгийн өрхүүд илүү хэрэглэдэгтэй холбоотой.

Зураг 11. Хамгийн их эрэлттэй дотоодын хүнсний ногоо, давтамж




Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Судалгаанд оролцсон бүх аж ахуйн нэгжүүд хэрэглэгчдийг импортын хүнсний ногооноос илүүтэй дотоодын хүнсний ногоог хэрэглэх хандлагатай гэж үзсэн. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 88% нь хэрэглэгчид үнээс үл хамааран дотоодын хүнсний ногоо хэрэглэх хандлагатай гэсэн бол 12% нь үнэ боломжийн ойролцоо үед дотоодын хүнсний ногоог илүү худалдан авдаг гэж хариулсан.

Мөн хэрэглэгчид дотоодын хүнсний ногоог худалдан авахдаа шинэ байдлыг хамгийн их харгалзан үздэг ажээ. Гэхдээ хүнсний ногооны үнэ, гарал үүсэл ч бас сонголт хийхэд чухал ач холбогдолтой байна.

Зураг 12. Хэрэглэгчдийн дотоодын хүнсний ногоо худалдан авахдаа чухалчилдаг шинж, давтамж




Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Хүнсний ногооны салбарын өөр нэг том хэрэглэгч нь **нийтийн хоолны салбар** юм. Энэ салбарын хүнсний ногоо хэрэглэх хандлагыг тодруулахын тулд бид Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын 18 рестораны менежерүүдээс нэмэлт мэдээлэл цуглууллаа (судалгаанд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжийн жагсаалтыг хавсралтаас үзнэ үү). Өргөн хүрээтэй мэдээлэл авахын тулд байгууллагын, сургуулийн, зочид буудлын ресторан болон сүлжээ рестораныг хамруулсан. Судалгаанд оролцсон бараг бүх ресторан дотоодод тарьж ургуулсан төмс, лууван, сонгино, байцай, өргөст хэмх, улаан лоолийг хоол бэлтгэхэд хэрэглэдэг бол шар манжин, саримсыг хамгийн бага хэрэглэж байна. Мөн дотоодод тарьж ургуулсан салатны навч, чинжүү, бууцай, хулуу зэрэг ногоог зарим ресторан үйлчилгээндээ хэрэглэж байна. Эдгээр нарийн ногоог Дархан, Эрдэнэт

зэрэг газар тариалангийн гол бүсэд ойр байрлалтай хотод үйл ажиллагаа явуулдаг ресторанууд түлхүү хэрэглэх хандлагатай.

Зураг 13. Рестораны хамгийн их ашигладаг дотоодын хүнсний ногоо, давтамж




Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Хэрэглээний дээрх хандлага нь, нэг талаас, ресторанаар үйлчлүүлэгчдийн таашааж хэрэглэдэг хүнсний ногооны хэрэглээг, нөгөө талаас, аль ногоог дотоодод түлхүү тарьж ургуулдгийг илэрхийлж байна. Өрхийн хэрэглээтэй харьцуулахад ресторануудын, өргөст хэмх, улаан лоолийн хэрэглээ их байна.

Ресторануудын хувьд дотоодод бага тариалдаг, эсвэл ургадаггүй нарийн ногоо их хэрэглэдэг тул импортын ногоо авахаас өөр аргагүй болдог бөгөөд тэдний хэрэглэж буй өргөст хэмх, улаан лоолийн нэлээд хэсгийг импортын ногоо эзэлдэг. Энэ хандлагыг дараах зурагт харуулав.

Зураг 14. Рестораны хүнсний ногооны хэрэглээний бүтэц, дунджаар




Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Дунджаар нэг рестораны хэрэглэж буй төмсний 94%-ийг монгол төмс эзэлдэг. Бусад ногоотой харьцуулахад өргөст хэмх, саримс, улаан лоолийн хэрэглээнд импортын эзлэх хувь хамгийн их буюу 40% - 46% байна. Мөн дотоодод тариалсан нарийн ногооны олдоц намраас бусад улиралд эрс багасдаг бөгөөд өвөл хаврын улиралд импортын нарийн ногоог түлхүү ашигладаг.

Ихэнх ресторанууд хүнсний ногоо худалдан авахдаа тухайн ногооны шинэлэг байдлыг хамгийн их харгалзаж үздэг байна. Үүний дараа тухайн ногооны гарал үүслийг чухалчилдаг аж. Энэ хандлагыг дараах зурагт харуулав. Хүнсний ногооны үнийн талаарх ресторануудын хандлага нь дээр дурдсан худалдаа эрхлэгчдийн үнэлэлтээс зөрж байна. Энэ нь ресторануудын хувьд хүнсний ногооны орцын өртөг хоолны үнэд харьцангуй бага хувь эзэлдэг, хоолныхоо амт чанарыг бууруулахгүйн тулд хүнсний ногооны чанарыг чухалчилдагтай холбоотой.

Зураг 15. Рестораны хүнсний ногоог худалдан авахдаа чухалчилдаг шинж, давтамж



Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Шинэ байдал, гарал үүслийг чухалчилдаг учраас судалгаанд оролцсон ресторанууд бүгд импортын хүнсний ногооноос дотоодын хүнсний ногоог илүү хэрэглэх хандлагатай байна. Тухайлбал, 18 рестораны 14 нь дотоодын хүнсний ногоог үнээс үл хамааран импортын ногооноос илүүд үздэг бол 2 нь ойролцоо үнэтэй үед дотоодын ногоог илүүд үздэг, 2 нь дотоодын хүнсний ногоо шинээрээ, чанартай тохиолдолд худалдан авдаг гэж хариулжээ.

4. Хүнсний ногооны үнэ цэний сүлжээний шинжилгээ

Хамгийн өргөн хэрэглэгддэг хүнсний ногооны үнэ цэний сүлжээн дэх өртгийн нэмэгдлийн ойролцоо тооцоог дараах хүснэгтэд харуулав. Ингэхдээ тухайн төрлийн хүнсний ногооны эцсийн хэрэглэгчид очиж буй үнэтэй харьцуулахад өртгийн сүлжээний үе шат бүрд ямар хэмжээний өртөг нэмэгдэж буйг хүнсний ногоо тус бүрээр ойролцоогоор илэрхийлэв.

Хүснэгт 3. Дотоодод тарьсан хүнсний ногооны өртгийн сүлжээнд нэмж буй өртгийн хувь

	Завсрын орц нийлүүлэгч	Тариаланчид	Борлуулагчид, зуучлагчид, агуулах	Нийт
Төмс	22%	34%	44%	100%
Лууван	19%	41%	44%	100%
Байцай	24%	32%	40%	100%
Сонгино	51%	42%	7%	100%

Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Гэхдээ дээрх хүснэгтэд харуулсан тооцоо нь ялгаатай эх сурвалжуудын тоон мэдээлэлд үндэслэсэн гэдгийг энд дурдах нь зүйтэй. Иймээс дээрх тооцоо нь нэмүү өртгийн сүлжээний талаарх ерөнхий төсөөллийг л өгөх бөгөөд нарийвчилсан үнэлгээ биш болохыг анхаарна уу.

Тайлангийн дараагийн хэсгүүдэд бид хүнсний ногооны үнэ цэний сүлжээний шинжилгээг хийхдээ бид эхлээд анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглан үйлдвэрлэгчийн ба хэрэглэгчийн үнүүд, тэдгээрийн зөрүүг тодорхойлохыг оролдлоо. Үүний дараа, уг үнийн зөрүүг голлон үүсгэж буй түгээлтийн шатны үйл ажиллагаануудын талаар өөрсдийн хийсэн түүвэр судалгааны мэдээлэлд үндэслэн зарим шинжилгээ хийв. Эцэст нь, нэмүү өртгийн сүлжээний чухал хэсэг байх учиртай боловсруулсан хүнсний ногооны зах зээлийн талаар тойм дүр зураг гаргахыг оролдов.

4.1. Үнийн шинжилгээ

4.1.1. Үйлдвэрлэгчийн үнэ, үйлдвэрлэгчийн нэмэгдэл өртөг

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын (FAO) статистик мэдээллийн санд манай улсын газар тариалангийн үйлдвэрлэгчийн үнийг жилээр, хүнсний ногоо бүрээр нэгтгэн танилцуулдаг. Гэхдээ энэ нь газар тариалан эрхлэгч өрхүүдийн түүвэр судалгаанаас тооцсон үнээс ихээхэн зөрүүтэй байгаа тул энэ судалгаанд бид уг статистик мэдээллийн оронд ҮСХ-ны түүвэр судалгаанууд болон бусад судалгааны мэдээллийг голчлон ашиглалаа.

Монголын ҮСХ-ны 2015 оны ХАА-н түүвэр судалгаанд 4,343 өрхийн мэдээлэлд үндэслэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнийг тооцсон байдаг (ҮСХ, 2016). Бид энэ судалгаанд 2017 оны ҮСХ-ны ӨНЭЗС-д хамрагдсан газар тариалан

эрхлэгч 256 өрхийн анхдагч мэдээллээс хүнсний ногоо тус бүрийн үйлдвэрлэгчийн үнийг тооцсон. Үүн дээр нэмээд, 2019 оны 1-р сард бид өөрсдийн гүйцэтгэсэн Сэлэнгэ, Булган аймгийн 11 тариаланч өрхийн түүвэр судалгаанаас хүнсний ногоо тус бүрийн үйлдвэрлэгчийн үнийг тооцов. Эдгээр үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Хүнсний ногооны үйлдвэрлэгчийн дундаж үнэ, төгрөг/кг

	2015 он*	2017 он**	2018 он***
Төмс	419	500	590
Лууван	1083	696	765
Манжин	1114	900	727
Байцай	1081	900	764
Сонгино	1462	1500	1330
Улаан лооль	2638	2500	2820
Өргөст хэмх	1866	2500	1800
Саримс	-	-	15700

Эх сурвалж: * - ҮСХ-ны ХАА-н түүвэр судалгаа-2015,

** - ҮСХ-ны ӨНЭЗС-д суурилсан судалгааны багийн тооцоолол

***-ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

2015-2018 онд төмс, улаан лоолийн үйлдвэрлэгчийн үнэ өссөн бол бусад ногооны үйлдвэрлэгчийн үнэ нэлээд буурчээ. Гэхдээ энэ харьцуулалт нь гурван өөр эх сурвалжийн мэдээлэлд суурилсан, түүврийн хэмжээ, үнэ тооцсон аргачлал нь нэлээд ялгаатай болохыг анхаарах хэрэгтэй. Хэрвээ тариаланчид том зах зээлд ойр, эрт ургацын ногоо борлуулдаг байвал талбай дээрээс борлуулсан үнэ нь өндөр байх хандлагатай.

Булган, Сэлэнгэ аймгийн 11 тариаланч өрхтэй хийсэн ярилцлагаас үзэхэд, төмс, лууван, манжин, байцай, сонгино зэрэг үндсэн ногоог бараг бүх өрх тариалсан бөгөөд судалгаанд хамрагдсан тариаланчдын онцлогоос хамаарч хамгийн их хураасан ургац нь байцай байлаа.

Хүснэгт 5. Өрхийн дундаж тариалалт ба борлуулалт

	Тариалсан өрхийн тоо	Хураасан ургац, кг	Борлуулсан, кг
Төмс	10	8550	5987
Лууван	10	2527	2017
Манжин	11	2395	2228
Байцай	11	22477	22477
Сонгино	10	1460	1340
Саримс, сүлжээ	7	208	143
Улаан лооль	9	544	337
Өргөст хэмх	8	550	338
Брокколи	3	150	150
Амтат чинжүү	2	100	30
Бууцай	2	63	63

Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Үндсэн ногооны хажуугаар зарим тариаланч брокколи, улаан саримс, амтат чинжүү, бууцай, гоньд, жууцай, шийгуа, артишок зэрэг ногоог тариалж, борлуулдаг ажээ.


Судалгаанд хамрагдсан Булган аймгийн Сэлэнгэ сумын тариаланчид ногоогоо ихэвчлэн талбай дээрээсээ хүнсний ногоо дамжуулан борлуулдаг хувь хүмүүс, байгууллагад худалдахаас гадна ойролцоох Эрдэнэт хот руу тээвэрлэн хүргэж, хүнсний захын худалдаачдад бөөнөөр борлуулдаг аж. Харин Сэлэнгэ аймгийн Мандал сумын тариаланчид ногоогоо ихэвчлэн Улаанбаатар хот руу тээвэрлэн “Барс” зэрэг хүнсний ногооны том захын худалдаачдад бөөнөөр борлуулахаас гадна намар Улаанбаатар хотод зохион байгуулагддаг яармаг худалдааны үеэр өөрсдөө хэрэглэгчдэд шууд жижиглэн борлуулдаг ажээ.

Тариаланчид хүнсний ногооны үнэ тогтоохдоо бүгд тухайн үеийн зах зээлийн үнийг дагадаг. Энэ нь тэд өөрсдийн зардал, алдагдлаа тооцож үнэ тогтоох биш, харин худалдан авагчтай тохиролцох, эсвэл худалдан авагчийн тогтоосон үнээр ногоогоо борлуулдаг гэсэн үг юм.

Үйлдвэрлэгчийн үнэтэй холбоотой нэг чухал асуудал нь энэ үнэд завсрын хэрэглээ болон нэмэгдэл өртгийн харьцаа хэр байгааг тооцох явдал юм. ҮСХ-ны 2015 оны дэлгэрэнгүй түүвэр судалгаагаар, газар тариалангийн бүтээгдэхүүн **үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг 50.9%-тай** тэнцэж байжээ. Гэхдээ энэ тооцоонд үр тариа, тэжээлийн ургамал тариалдаг өрхүүдийг хүнсний ногоо тарьдаг өрхүүдтэй хамтатгаж тооцсон гэдгийг анхаарах хэрэгтэй. Иймээс үр, шатахуун гэх мэт зардал ихтэй үр тариа тариалагч өрхүүдийн завсрын хэрэглээ нийт нэмэгдэл өртгийн эзлэх жинг нэлээд бууруулсан байх талтай.

Харин 2017 оны ҮСХ-ны ӨНЭЗС-ны мэдээлэл хийсэн нэмэлт шинжилгээгээр, хүнсний ногоо тариалагчдын **үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг 69.9%** гарсан. Үүнийг тодруулж авч үзье. Тухайлбал, 2017 онд хүнсний ногоо тариалдаг өрхийн жилийн борлуулалтын орлого дунджаар 1,517,000 төгрөг байсан бол зарлага нь 685,000 төгрөг байжээ.

Зураг 16. Хүнсний ногоо тариалах зардлын бүтэц



Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС 2017 болон судалгааны багийн тооцоолол

Үүнээс, тариаланчдын хүнсний ногоо тариалахтай холбоотой зардлын бүтцийг харвал хөдөлмөрийн хөлс, түүхий эд, шатахуун, үрийн зардал дийлэнхийг эзэлж байна.

Дээрх зардлуудаас цалин хөлс, татвар хураамж нь хүнсний ногоо тариалагчдын нэмэгдэл өртөгт тооцогдоно. Мөн өрхийн газар тариалангийн үйлдвэрлэлийн ашиг/алдагдлыг нэмэгдэл өртөгт тооцно. Нийлбэр дүнгээр, 2017 онд хүнсний ногоо тариалагч өрхүүдийн завсрын хэрэглээ нь 30.1% болсон. Үлдэх 69.9% нь үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг бөгөөд үүний 14.4%-ийг цалин, 0.6%-ийг татвар, 54.9%-ийг тариаланчдын ашиг бүрдүүлж байна.

Хэдийгээр дээрх түүвэр судалгаанууд үндэсний хэмжээний судалгаа боловч нэмэгдэл өртгийн тооцоог өрхийн нийт үйлдвэрлэлийн хувьд авч үзсэн бөгөөд хүнсний ногоо тус бүрээр нэмэгдэл өртгийн талаар нарийвчлан тооцох боломжгүй юм. Хүнсний ногоо тус бүрийн нэмэгдэл өртгийг улсын хэмжээнд тооцсон, сүүлийн үеийн, нээлттэй судалгаа ховор байна. Харин зарим бүс нутгийг сонгож хийсэн доорх хоёр судалгааны үр дүнг SECiM төслийн хүрээнд 2018 онд хийгдсэн “Монгол Улсын ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт: үнэ цэний сүлжээтэй уялдах нь” судалгааны тайланд танилцуулжээ.

Төмсний үнэ цэний сүлжээний талаар судлаач Н.Батжаргалын 2015 онд гүйцэтгэсэн “Төмсний зах зээлийн РАМ шинжилгээ” сэдэвт докторын судалгааны ажилд нэлээд тодорхой харуулжээ (SECiM, 2018). Уг судалгааны түүвэрт хамрагдсан Төв, Сэлэнгэ аймгийн 207 ногоочин өрхийн хувьд 1 га газарт төмс тариалахад дунджаар 2,551 мянган төгрөгийн зардал гаргаж, 133 центнер ургац хураадаг ба 1 кг төмсийг 486 төгрөгөөр борлуулжээ. Үүний 191 төгрөг буюу 39.3% нь завсрын орцын хэрэглээ, **60.7% нь нэмэгдэл өртөг** (хөдөлмөрийн өртөг, үйлдвэрлэгчийн ашиг гэх мэт) байв. Харин тухайн үеийн хэрэглэгчийн үнэ 812 төгрөг байсан бөгөөд энэ нь бөөний болон жижиглэнгийн худалдааны шатанд нэмэгдэл өртөг 326 төгрөг буюу 67%-аар нэмэгдсэн гэсэн үг.

Бусад хүнсний ногооны үнэ цэний сүлжээний талаар судлаач С.Баасансүрэнгийн 2014 онд гүйцэтгэсэн судалгаанд тодорхой харуулжээ (SECiM, 2018). Судлаач Ховд аймгийн Буянт сумын 51 өрхөөс авсан түүвэр судалгаандаа зарим хүнсний ногооны нэмэгдэл өртгийг нарийвчлан тооцсон. Доорх хүснэгтэд үүнийг харуулав.

Хүснэгт 6. Зарим хүнсний ногооны өртгийн шинжилгээ, Ховд аймгийн Буянт сум, 2014 он

	Манжин	Байцай	Лууван	Сонгино
Үйлдвэрлэгчийн үнэ, төг	1309	1288	1309	1797
Завсрын хэрэглээ, төг	765	553	423	977
Завсрын хэрэглээ, %	58.4%	42.9%	32.3%	54.4%
Үйлдвэрлэгчийн нэмэгдэл өртөг, төг	544	735	886	820
Үйлдвэрлэгчийн нэмэгдэл өртөг, %	41.6%	57.1%	67.7%	45.6%

Эх сурвалж. (SECiM, 2018)

Дээрх хүснэгтээс харахад, 2014 онд Ховд аймгийн Буянт сумын хүнсний ногоо тариалдаг өрхүүдийн үйлдвэрлэгчийн нэмэгдэл өртөг 42% - 68% байжээ.

Хүнсний ногооны нэр төрлийг олшруулах, ногоо тариалах хугацааг уртасгах, тариаланчдын бүтээмжийг дээшлүүлэх, тариаланчдын үйлдвэрлэлийн нэмүү өртгийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэгчийн үнийг өсгөхөд хүлэмж, тариалангийн тусгай машин, тоног төхөөрөмж, агуулах зоорины хангамж чухал үүрэгтэй. Иймээс энэ судалгааны хүрээнд бид 2019 оны 1-р сард Сэлэнгэ аймгийн Мандал, Булган аймгийн Сэлэнгэ сумын 11 тариаланчтай ярилцлага хийж, эдгээр асуудлыг тодруулсан. Сонгосон тариаланчид орон нутагтаа 4-26 жил буюу дунджаар 18 жил ногоо тарьсан туршлагатай, 1-7 га буюу дунджаар 2.8 га газарт хүнсний ногоо тариалдаг тариаланчид байсан. Уг газар дээрээ зуны улиралд гэр бүлийн гишүүдээсээ гадна дунджаар 3 хүн, намар 12 хүн, хавар 5 хүн ажиллуулдаг ажээ.

Хүснэгт 7. Хүлэмж, трактор, агуулах ашиглалт

Судалгаанд хамрагдсан нийт тариаланчийн тоо	11
Хүлэмжтэй тариаланчийн тоо	Нийт 9. Үүнээс давхардсан тоогоор энгийн хүлэмжтэй 7, хагас тоноггосон хүлэмжтэй 3
Хүлэмжийн талбай	Хамгийн бага – 12 м.кв Хамгийн том – 3760 м.кв Дунджаар – 680 м.кв
Хүлэмж барьсан санхүүжилтийн эх үүсвэр	Давхардсан тоогоор 9 тариаланчийн 7 нь өөрийн хөрөнгөөр, 3 нь төсөл хөтөлбөрийн дэмжлэгээр, 1 нь түрээсээр
Хүлэмж ажиллуулах жилийн дундаж зардал	937,890 төгрөг
Тариалангийн машин, трактор ашигладаг тариаланчийн тоо	Тариаланчид 1-2 машин, трактор ашигладаг.
Машин, трактор авсан санхүүжилтийн эх үүсвэр	Давхардсан тоогоор 11 тариаланчийн 4 нь сумын захиргаанаас хөнгөлөлттэй үнээр трактор хөлсөлдөг, 4 нь бусдаас зах зээлийн үнээр түрээсэлдэг, 4 нь өөрийн хөрөнгөөр авсан, 2 нь төсөл, хөтөлбөрийн дэмжлэгээр авсан
Машин, трактор ажиллуулах жилийн дундаж зардал	681,820 төгрөг
Ногооны агуулах, зоорьтой тариаланчийн тоо	Нийт 9. Үүнээс давхардсан тоогоор нүхэн зоорьтой 7, температурын хяналттай агуулахтай 4.
Агуулах, зоорины талбай	Хамгийн бага – 46 м.кв Хамгийн их – 396 м.кв Дундаж – 170 м.кв
Агуулах, зоорь барьсан санхүүжилтийн эх үүсвэр	9 тариаланч бүгд өөрийн хөрөнгөөр барьснаас гадна 1 тариаланч нэмж арилжааны зээл авсан бол 1 тариаланч түрээсээр агуулах нэмж ашиглаж байна.
Агуулах, зоорь ажиллуулах жилийн дундаж зардал	157,780 төгрөг


Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Үүнээс гадна тариаланчид бага оврын ачааны машин, усны насос, жижиг гар багажийг тариалангийн үйл ажиллагаандаа өргөн ашиглаж байна.

4.1.2. Импортын үнэ

Хүнсний ногооны импортын үнэ нь бусад импортын барааны адил гол нийлүүлэгч БНХАУ-ын зах зээл дээрх хүнсний ногооны үнэ, валютын ханшаас голлон хамаарч өөрчлөгддөг. Гол хүнсний ногооны импортын үнийн сүүлийн жилүүдийн өөрчлөлтийг дараах зурагт харуулав. Сүүлийн жилүүдэд төгрөгийн ханш ихээхэн унасан нь дотоодын валютаар илэрхийлэх хүнсний ногооны үнийн өсөлтийг голлон тайлбарлаж байна.

Зураг 17. Импортын гол нэрийн хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг/кг



*Импортёр орж буй хүнсний ногооны нийт үнийн дүнг нийт тоо хэмжээнд харьцуулан тооцсон болно

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Үүнээс гадна хүнсний ногооны импортын үнэд импортын тариф чухал нөлөөтэй. Монгол Улсад импортоор орж ирж буй хүнсний ногоонд дараах хоёр төрлийн татвар ногдуулж байна.

- (i) Гаалийн албан татвар: төмс, бөөрөнхий байцай, шар лууван, шар манжин, өргөст хэмх, улаан лооль зэрэг дотоодод тариалдаг хүнсний ногоонууд импортод 20%, ногоон сонгино, сонгинын төрлийн бусад ногоод 15%, бусад төрлийн хүнсний ногоо болон зарим үндэс үрт ба булцуут үрт хүнсний ногоод 5%-ийн татвар ногдуулдаг.
- (ii) НӨАТ-ын хуульд зааснаар дотоодод үйлдвэрлэсэн газар тариалан эрхлэгчийн дотооддоо тарьж борлуулсан төмс, хүнсний ногоог НӨАТ-аас чөлөөлдөг бол импортын хүнсний ногоонд борлуулалтын үнэлгээний 10 хувьтай тэнцэх хэмжээний татвар ногдуулдаг.

Өмнөх хэсэг тооцсон үйлдвэрлэгчийн үнэтэй импортлогчийн үнийг харьцуулбал дараах сонирхолтой дүр зураг ажиглагдаж байна.

Хүснэгт 8. Хүнсний ногооны үйлдвэрлэгчийн ба импортлогчийн дундаж үнэ (төгрөг/кг), 2017

	Үйлдвэрлэгчийн дундаж үнэ*	Импортлогчийн дундаж үнэ**
Төмс	500	607
Лууван	696	444
Байцай	900	450
Сонгино	1500	519
Улаан лооль	2500	652
Өргөст хэмх	2500	566

Эх сурвалж: * - ҮСХ-ны ӨНЭЗС 2017-д суурилсан судалгааны багийн тооцоолол


** - Гаалийн ерөнхий газрын статистик мэдээлэл

Энэ харьцуулалтад ашигласан мэдээллийн эх сурвалжууд өөр, дундаж үнэ тооцсон аргачлалууд ялгаатай тул шууд харьцуулахад учир дутагдалтай боловч ерөнхий хандлагын талаар зарим нэг дүгнэлт хийж болох юм. Тухайлбал, дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж байгаа төмсний хувьд үйлдвэрлэгчийн үнэ импорттой өрсөлдөхүйц хямд байна. Харин дотоодын үйлдвэрлэгчдийн зах зээлд эзлэх хувь бага байх тусам үйлдвэрлэгчийн үнэ импортын үнээс төдий чинээ өндөр байх хандлагатай байна.

4.1.3. Хэрэглэгчийн үнэ

Хүнсний ногооны үнэ ерөнхийдөө зах зээлийн нийлүүлэлт, хэрэглэгчдийн худалдан авах чадвараас шалтгаалдаг. Иймээс намар шинэ ургацын ногооны нийлүүлэлт нэмэгдэхэд үнэ хямдарч, бусад улиралд үнэ нь өсдөг. Гэхдээ өрхүүдийн хамгийн их хэрэглэдэг хүнсний ногоонуудын үнийн хувьд улирлаас хамаарсан хэлбэлзэл харьцангуй бага ажиглагдаж байгааг доорх зургаас харж болно.

Зураг 18. Гол хүнсний ногооны үнэ (төгрөг/кг), улирлаар




Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС 2017 болон судалгааны багийн тооцоолол

ҮСХ-ны өрхийн зарлагын түүвэр судалгааны мэдээлэлд үндэслэн эдгээр бүтээгдэхүүний сүүлийн 3 жилийн дундаж үнийг байршлаар харьцуулан доорх зурагт харуулав. Төмс,

сонгинын үнэ Улаанбаатарт орон нутгийн зах зээлээс 10% орчим хямд байдаг бол байцай, луувангийн үнэ хот, хөдөөд нэлээд ойролцоо байна.


Зураг 19. Гол хүнсний ногооны үнэ (төгрөг/кг), байршлаар



Эх сурвалж: УСХ-ны ӨНЭЗС 2017 болон судалгааны багийн тооцоолол

Бусад хүнсний ногооны хувьд, саримсны үнэ сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа бол бусад ногооны үнэ харьцангуй тогтвортой байгааг доорх зургаас харж болно. Өргөст хэмхийн үнэ шинэ ургацын ногоо гарах үе буюу жилийн III улиралд нэлээд хүчтэй буурдаг бол улаан лооль, чинжүү зэрэг нарийн ногооны үнэ энэ үеэр бага зэрэг буурдаг байна.


Зураг 20. Бусад хүнсний ногооны үнэ (төгрөг/кг), улирлаар



Эх сурвалж: УСХ-ны ӨНЭЗС 2017 болон судалгааны багийн тооцоолол

Эдгээр бүтээгдэхүүний сүүлийн 3 жилийн дундаж үнийг байршлаар харьцуулан доорх зурагт харуулав. Чинжүү, саримсны үнэ Улаанбаатарт орон нутгийн зах зээлийн үнээс 20% орчим хямд байдаг бол манжин, улаан лооль, өргөст хэмхийн үнэ хот, хөдөөд ойролцоо байна.

Зураг 21. Бусад хүнсний ногооны үнэ (төгрөг/кг), байрилаар



Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС 2017 болон судалгааны багийн тооцоолол

4.1.4. Үйлдвэрлэгчийн ба хэрэглэгчийн үнийн зөрүү

Өмнөх хэсгүүдэд тооцсон хүнсний ногооны үйлдвэрлэгчийн ба хэрэглэгчийн үнийг харьцуулан дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 9. Хүнсний ногооны үйлдвэрлэгчийн ба хэрэглэгчийн дундаж үнэ (төгрөг/кг), 2017

	Үйлдвэрлэгчийн дундаж үнэ	Хэрэглэгчийн дундаж үнэ	Үнийн зөрүү
Төмс	500	895	79%
Лууван	696	1241	78%
Манжин	708	1320	86%
Байцай	900	1496	66%
Сонгино	1500	1608	7%
Улаан лооль	2500	4746	90%
Өргөст хэмх	2500	4225	69%

Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС 2017-д суурилсан судалгааны багийн тооцоолол

Үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн үнийн зөрүү сонгиноос бусад хүнсний ногооны хувьд 66% - 90% байна. Сонгинын хувьд энэ зөрүү дөнгөж 7% байгаа нь зах зээлд дотоодын сонгинын эзлэх хувь бага, импортын сонгино их хэмжээгээр харьцангуй хямд нийлүүлэгдсэнтэй холбоотой байж болох юм. Гэхдээ үүнтэй харьцуулахад хямд импортын бүтээгдэхүүний эзлэх жин ихтэй улаан лооль, өргөст хэмх зэрэг ногооны хувьд хэрэглэгчийн үнэ маш өндөр байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь ерөнхийдөө эдгээр нарийн ногооны борлуулалт хязгаарлагдмал, борлуулах үе шатанд гарах алдагдал болон хадгалалтын зардал өндөр зэрэгтэй холбоотой байж болох юм.

Нэмэгдэл өртгийн дээрх их хэмжээний зөрүү нь хүнсний ногоог тариаланчдаас хэрэглэгчдэд хүргэх үе шатанд үүсэж байгаа бөгөөд энэ талаар дараагийн хэсэгт дэлгэрүүлж авч үзье.

4.2. Хүнсний ногооны түгээлтийн үе шат

Хүнсний ногоог хэрэглэгчдэд хүргэх түгээлтийн үйл явцад гол оролцогчид бол агуулах, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчид, зуучлагчид юм. Бид энэ судалгааны хүрээнд эхний хоёр оролцогчийн төлөөлөлтэй ярилцлага хийж, үйл ажиллагааных нь талаар дэлгэрүүлж авч үзсэн.

4.2.1. Агуулахын үйл ажиллагаа


Энэ судалгааны хүрээнд хийсэн Булган, Сэлэнгэ аймгийн тариаланчдын ярилцлагаас үзэхэд, ихэнх тариаланчид зориулалтын бус, дулааны тохируулгагүй агуулах, зоорь эзэмшдэг, эсвэл агуулах зоорь хүрэлцдэггүйгээс тариалсан хүнсний ногоогоо хураасан даруйдаа шууд бөөний төв, зах эсвэл зуучлагчдад худалддаг ажээ. Энэ нь хүнсний ногоогоо илүү өндөр үнээр зарах боломжийг хязгаарладаг. Үүнээс гадна тариаланчид үнэтэй боловч хадгалахад хэцүү, технологи шаарддаг байцай, навчит ургамал, улаан лооль тарихаас зайлсхийж, орлогоо нэмэх боломжоос татгалздаг. Мөн хадгалалтыг зөв хийгээгүйгээс болж хүнсний ногоо агуулахаас гаргасны дараа богино хугацаанд муудаж алдагдал хүлээх тохиолдол их гардаг. Энэ мэт бэрхшээлийг шийдвэрлэх гол алхам нь стандарт шаардлагад нийцсэн агуулах, зоорины хангамжийг нэмэх явдал юм.

Бид энэ судалгааны хүрээнд мөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуйн нэгж, иргэдтэй ярилцлага хийж, бизнесийнх нь талаар мэдээлэл цуглуулсан (судалгаанд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжийн жагсаалтыг хавсралтаас үзнэ үү). Тэдний 3 нь энгийн нүхэн зоорьтой бол 2 нь дулааны тохируулгатай, 2 нь төв шугамын халаалттай агуулахтай байв. Тэдний 4 нь өөрийн эзэмшдэг байгууллагын, 3 нь намар нөөцлөөд өвөл, хавар худалдах зорилгоор, 2 нь түрээслэх, 1 нь гэрээт байгууллагын ногоог хадгалах, 1 нь өөрийн тарьсан ногоог хадгалж зарах зорилгоор агуулах ажиллуулж байна.

Тэд дотоодын хүнсний ногоог өөрийн тариалан болон гэрээт компани, бусад тариаланчдаас ихэвчлэн авдаг бол импортын ногоог Оросоос шууд, Хятадын Импортлогчдын холбоо болон Naogan компаниар дамжуулж авдаг ажээ. Дотоодын ногоог борлуулахдаа тэдний 6 нь супермаркет, захад, 3 нь нийтийн хоолны газруудад, 2 нь сургууль, албан байгууллагын хоолны газарт, 1 нь ногоо боловсруулах үйлдвэрт нийлүүлдэг байна. Харин агуулах дахь импортын ногоог ихэвчлэн зах дэлгүүрүүдэд борлуулдаг байна.

Өөрийн эзэмшдэг байгууллагын ногоог хадгалдаг 1 агуулах л хүчин чадлаа 10% ашиглаж байгаа бол бусад бүх агуулах хүчин чадлаа 100% ашиглаж байна. Энэ нь агуулахын эрэлт хэрэгцээ маш их байгааг илтгэж байна. Агуулахууд дотоодын хүнсний ногооноос төмс, сонгиныг бүгд хадгалдаг бол 6 нь лууван, манжин, 5 нь байцай, 3 нь саримс хадгалдаг. Тэдний агуулахын хэдэн хувийг дотоодын хүнсний ногоо эзэлж буйг дараах зурагт харуулав.

Зураг 22. Агуулах дахь ногооноос дотоодын хүнсний ногооны эзлэх хувь




Дээрх зургаас харахад, агуулахад хадгалж буй гол нэр төрлийн ногооны дийлэнх нь дотоодын хүнсний ногоо эзэлж байна. Агуулахын бизнес эрхлэгчдийн 4 нь өөрсдийн тарьсан ногоог хадгалах, гэрээт болон өөрийн эзэмшдэг байгууллагын ногоог хадгалах зорилготой учраас дотоодын хүнсний ногоо хадгалахыг илүүд үзэж байна. Мөн дэмжих шаардлагатай, эсвэл импортын ногооноос илүү эрэлт ихтэй гэдэг шалтгаанаар дотоодын хүнсний ногоог хадгалахыг илүүд үзэх бизнес эрхлэгчид ч байна. Харин тэдний 3 нь одоо ч дотоодын ногоог илүү их хадгалдаг учраас дотоодын ногоог заавал импортын ногооноос илүүд үзэж хадгалах шалтгаан байхгүй гэж хариулсан. Гэхдээ Улаанбаатарын хүнсний ногооны агуулах төвлөрдөг “Барс” захад агуулах эзэмшдэг нэгэн худалдаачин тус захын удирдлага импортоор оруулж ирсэн хүнсний ногоогоо заавал хадгалж борлуулахыг тус зах дээр агуулах эзэмшигчдэд тулгадаг бөгөөд агуулахууд импортын ногоог (20% орчим) дотоодын ногоотой хольж борлуулдаг тухай мэдээлсэн нь анхаарал татаж байв.

Агуулахын бизнес эрхлэгчдийн хувьд хадгалах сонирхол хамгийн ихтэй ногоо нь бараг бүх оролцогчийн саналаар нэгдүгээрт төмс, хоёрдугаарт лууван ажээ. Үүний гол шалтгаан нь эрэлт хэрэглээ ихтэй, хадгалахад хялбар байдагтай холбоотой аж. Эдгээрийн дараа манжин, байцай, сонгиныг ойролцоо эрэмбэлэх хандлагатай байв. Гэхдээ нэг оролцогчийн хувьд хавар борлуулахад үнийн зөрүүнээс ашиг их олдог шалтгаанаар байцайг хамгийн их хадгалах сонирхолтой байв.

4.2.2. Бөөний болон жижиглэн худалдаа

Нэмүү өртгийн сүлжээний гол үе шат болох хүнсний ногооны борлуулалтын талаар тодруулахын тулд бид Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын 18 зах, супермаркетыг сонгож судалгаанд хамруулсан (судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн жагсаалтыг хавсралтаас үзнэ үү). Зах, супермаркетууд бараг бүгд төмс, лууван, байцай сонгино саримс, шар манжин зэрэг ногоог худалддаг. Харин ихэнх захуудын хувьд хүнсний ногооны лангуу нарийн, бүдүүн ногоогоор төрөлжсөн байдаг тул нарийн ногоо зардаг зах, супермаркетууд арай цөөн байна.

Зураг 23. Зах, супермаркетад худалдаалж буй хүнсний ногооны бүтэц, дунджаар



Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Зах, супермаркетуудад зарагдаж буй саримсны дунджаар 61% -ийг импортын саримс эзэлдэг. Харин хүрэн манжин, төмс, лууван, шар манжин зэрэг хүнсний ногооны дийлэнх буюу дунджаар 95% -аас дээш хувийг дотоодын ногоо бүрдүүлдэг. Нарийн ногоо болох өргөст хэмх, улаан лоолийн нэлээд хувийг импортын ногоо эзэлдэг.

Судалгааны хүрээнд зах, супермаркетууд борлуулалтын үнээ хэрхэн тодорхойлдог, зардал дээр хэдэн хувийн нэмэгдэл тооцдог болохыг эхлээд тодруулсан. Мэдээллийг бататгах үүднээс ногоо тус бүрийн борлуулалтын үнэ ба худалдаж авсан үнийг мөн нэмж асуусан.

Эхний ерөнхий асуултад зах, супермаркетууд хүнсний ногоо худалдаж авсан үнэ дээр дунджаар 17%-ийн нэмэгдэл тооцож борлуулалтын үнээ тодорхойлдог гэж хариулсан. Үүнээс, Эрдэнэт хотын хүнсний захын худалдаачин авсан үнэ дээр 30%-ийн нэмэгдэл тооцож борлуулдаг нь хамгийн өндөр тохиолдол бол “Гацуурт” компанийн нэрийн барааны дэлгүүр өөрийн тариалсан ногоог ямар нэг нэмэгдэлгүй борлуулдаг нь хамгийн бага тохиолдол юм.

Үүний дараа бид худалдаачдаас одоогийн байдлаар хүнсний ногоо тус бүрийг ямар үнээр худалдан авч, ямар үнээр борлуулж буйг нарийвчилж асуухад дараах үр дүн гарсан.


Хүснэгт 10. Зах, супермаркетад худалдаалж буй хүнсний ногооны үнэ, дунджаар, төгрөг/кг

	Төмс	Лууван	Байцай	Сонгино	Шар манжин	Улаан лооль	Өргөст хэмх
Борлуулж буй үнэ	1104	1356	1395	1892	1304	6878	7089
Худалдаж авсан үнэ	862	1040	1013	1449	915	5502	5666

Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Хүнсний ногоо тус бүрийн худалдсан болон худалдаж авсан үнийн зөрүү буюу худалдааны нэмэгдлийг дараах зурагт харуулав.

Зураг 24. Зах, супермаркетэд худалдаалж буй хүнсний ногооны үнийн нэмэгдэл хувь, дунджаар




Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Дээрх зургаас харахад борлуулалтын үнээ тодорхойлж буй зардлын нэмэгдэл хувь шар манжин дээр хамгийн өндөр буюу 43%, төмсний хувьд хамгийн бага буюу 28% байна. Энэ нь зардал дээр хэдэн хувийн нэмэгдэл тооцдог вэ гэсэн ерөнхий асуултын хариулттай харьцуулахад хавьгүй өндөр байгаа боловч 4.1.4 дэх хэсэгт тооцсон үйлдвэрлэгчийн ба хэрэглэгчийн үнийн зөрүүгээс доогуур байна. Үүний шалтгаан нь хүнсний ногоо хэрэглэгчдийн гарт хүрэхдээ эдгээр зах, дэлгүүрийн зөвхөн нэгийг дамжихгүй, борлуулалтын хэд хэдэн шат дамждагтай холбоотой.

Иймээс судалгаанд хамрагдсан зах, дэлгүүрүүд бүтээгдэхүүнээ хаанаас бөөнөөр худалдаж авдгийг тодруулах шаардлагатай. Энэ хандлагыг дараах зурагт харуулав.

Зураг 25. Зах, супермаркетуудын хүнсний ногоо худалдан авдаг нийлүүлэгч, давтамж



Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Зах, супермаркетуудын дийлэнх нь дундын зуучлагчаас хүнсний ногоо бөөнөөр нь худалдан авдаг. Тэр дундаа импортын хүнсний ногоог зуучлагчаас худалдаж авах нь нийтлэг байна. Зах, супермаркетууд өөрсдийн борлуулах хүнсний ногоог бусад томоохон захуудаас худалдан авах тохиолдол нийтлэг. Бусад захаас хүнсний ногоо авч буй бараг бүх супермаркет захууд “Барс” захаас хүнсний ногоог худалдан авдаг ажээ. Харин “Барс” захад худалдаа эрхлэгчид импортын хүнсний ногоог өөрсдөө импортолж оруулж ирдэг ба монгол ногоог шууд тариаланчаас худалдан авч цааш борлуулдаг. Мөн

зарим зах, супермаркетууд монгол хүнсний ногоог шууд тариаланчаас авдаг. Зарим тохиолдолд тариаланчид супермаркетуудад шууд өөрсдөө ханддаг бөгөөд үнэ тохиролцон ногоогоо худалддаг байна. Хөдөө орон нутагт тариалан эрхэлдэг хамаатан, танилтайгаа хамтран ажиллаж, тэдний ногоог өөрийн лангуу, дэлгүүрээр борлуулах тохиолдол байдаг. Мөн зарим зах, супермаркетууд тариалан эрхэлдэг “Гацуурт” гэх мэт том компаниас хүнсний ногоо худалдан авдаг байна.

Зах, супермаркетуудад дотоодын хүнсний ногоог ихэвчлэн нийлүүлэгч тал нь хүргэж ирдэг. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг, бусад захаас хүнсний ногоо худалдан авдаг зарим зах, супермаркетууд монгол хүнсний ногоог өөрсдөө борлуулагчаас очиж худалдан авдаг. Харин импортын хүнсний ногоог зарим хэсэг нь хүргэлттэй авдаг бол зарим хэсэг нь өөрсдөө очиж авдаг бөгөөд тодорхой хандлага ажиглагдаагүй. Гэхдээ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг зах супермаркет ихэвчлэн импортын хүнсний ногоог “Барс” захаас өөрсдөө очиж худалдан авдаг.

Бараг бүх, зах супермаркетууд тариаланчдаас хүнсний ногоо шууд худалдан авах сонирхолтой байна. Зарим зах, супермаркетууд хүнсний ногоог тариаланчаас шууд худалдан авдаг бөгөөд ингэхдээ дараах хэлбэрээр хамтран ажиллаж байна.

- Цөөн тооны тариаланчидтай тогтмол хамтрах. Муудсан, чанаргүй ногоог буцаадаггүй. Гэхдээ анх ногоог авахдаа хорогдол тооцож авдаг.
- Үзэсгэлэн худалдаанаас худалдан авдаг. Заримдаа тариаланчид ирж ногоо худалдан авахыг санал болгодог.
- Өөрийн тариалангийн аж ахуйтай “Гацуурт” зэрэг том компаниуд өөрийн сүлжээ дэлгүүрээр зардаг.
- Тариалан эрхэлдэг төрөл садан, дотнын хүнээс худалдан авдаг. Ингэхдээ “Барс” захын үнийг жишиг болгодог.

Хүнсний ногоог тариаланчаас шууд худалдан авах хүсэлтэй бусад зах, супермаркетууд тариаланчдад дараах шаардлагыг тавьж байна. Үүнд:

- Шинэ, эрүүл, чанараа алдаагүй
- Сайн ялгасан
- Хүнсний ногооны хэмжээ том
- Хүргэлттэй
- Хадгалалтын горим зөрчөөгүй, зөв хадгалсан, хөлдөөгүй
- Үнэ боломжийн хямд
- Буцаалт хийх боломжтой
- Гарал үүсэл тодорхой, шинжилгээний бичигтэй

4.3. Нийтийн хоолны салбар

Хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээнд чухал байр суурь эзэлдэг оролцогчид бол нийтийн хоолны газрууд юм. Тэдний хувьд бэлтгэж буй хоолны гол орц болох хүнсний ногоог хэрхэн худалдан авдгийг энэ судалгааны хүрээнд тодруулахыг зорьсон. Ярилцлагын үр дүнгээс үзэхэд, Дархан, Эрдэнэт хотуудад үйл ажиллагаа явуулдаг ресторанууд ихэвчлэн орон нутгийн хүнсний зах, бөөний төвүүдээс өөрсдийн хэрэгцээт хүнсний ногоог худалдан авч байна. Дархан хотын зарим ресторан импортын хүнсний ногоог Улаанбаатар хотын “Меркури” “Барс” зэрэг захуудаас хүргүүлж худалдан авдаг. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ихэнх ресторанууд “Барс” захаас хүнсний ногоо худалдан авдаг ажээ. Томоохон ресторанууд хүнсний ногооны тариалагчидтай, эсвэл зуучлагч компаниудтай шууд гэрээ байгуулж хамтран ажиллах тохиолдол элбэг байна. Мөн ихэнх ресторануудад хүнсний ногоог хүргэж өгдөг борлуулагчид байдаг ажээ.

Судалгаанд оролцсон ресторанууд хэрэгцээт хүнсний ногоог тариаланчаас шууд худалдан авахдаа дараах хэлбэрээр хамтран ажиллаж байна. Үүнд:

- Тариаланчид дээр очиж үнээ тохиролцон чанарыг нь шалгаж авдаг. Ингэхдээ ямар нэг гэрээ хийдэггүй.
- Гэрээ байгуулж хамтран ажилладаг. Гэрээний дагуу хүнсний ногоог урьдчилан авдаг, тооцоог сарын сүүлд хийдэг. Буцаалт хийх боломжтой, ногоог нийлүүлэгч тал хүргэж ирдэг. Ингэхдээ чанар, хэмжээгээр ялгасан байдаг.
- Удаан хугацаанд нэг тариаланчтай хамтран ажиллаж, хүнсний ногоо худалдан авдаг.
- Өөрсдөө тариалан эрхэлдэг компаниудтай хамтран ажилладаг.

Хүнсний ногоог тариаланчаас шууд худалдан авах хүсэлтэй ресторанууд тариаланчдад дараах шаардлагуудыг тавьдаг болохыг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Шинэ, эрүүл, чанараа алдаагүй байх
- Найдвартай цаг хугацаандаа тогтмол нийлүүлэлт хийдэг байх
- Үнэ нь улирлаас хамааран хэлбэлздэггүй, тогтмол байх
- Хүргэлттэй байх
- Хадгалалтын горим зөрчөөгүй, зөв хадгалсан байх
- Үнэ боломжийн хямд
- Буцаалт хийх боломжтой
- Гарал үүсэл тодорхой
- Санхүүгийн баримт өгдөг байх
- Ногооны хэмжээ жигд, стандартад нийцсэн том байх


4.4. Боловсруулсан хүнсний ногооны зах зээл

Хүнсний ногооны салбарын нэмүү өртгийн сүлжээнд чухал байр суурь эзлэх ёстой үе шат бол хүнсний ногооны боловсруулалт юм. Харамсалтай нь манай улсын хэмжээнд боловсруулсан хүнсний ногооны хэрэглээ маш бага байдаг. Дээр нь, дотоодын үйлдвэрлэл бараг хөгжөөгүй, хэрэглээний дийлэнхийг импортоор хангадаг.

Гаалийн ерөнхий газрын цахим хуудасны мэдээллээс боловсруулсан хүнсний ногооны импортын талаар тодруулж авч үзэв. 2018 оны байдлаар, нийт боловсруулсан хүнсний ногооны импорт 21.6 сая ам.доллар болжээ. Энэ дүнг лаазалсан болон бусад хагас боловсруулсан гэсэн хоёр бүлэгт хувааж авч үзье.

Боловсруулсан ногооны импортын дийлэнх хэсгийг эзэлдэг лаазалсан бүтээгдэхүүний импорт сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгааг доорх зургаас харж болно. Энэ нь ерөнхийдөө эдийн засгийн өсөлт буюу өрхийн худалдан авах чадвар нэмэгдэж буйтай холбоотой. Тухайлбал, 2016 онд эдийн засгийн өсөлт саарч, иргэдийн орлого буурах үед лаазалсан ногооны импорт 12.1 сая ам.доллар байсан бол түүнээс хойш эдийн засаг сэргэхэд энэ үзүүлэлт өссөөр, 2018 онд 19.5 сая ам.доллар болжээ.


Зураг 26. Лаазалсан хүнсний ногооны импорт, мянган ам.доллар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Пүнтүүз, цардуул, бусад хагас боловсруулсан хүнсний ногооны 2012 оноос хойш эрс нэмэгдэж, 2014 онд хамгийн их түвшиндээ хүрч, жилдээ 2.9 сая ам долларын бүтээгдэхүүн импортолжээ. Түүнээс хойш импорт буурсаар 2016 оноос хойш эргээд өсөх хандлагатай байна. Гэхдээ шууд хэрэглэх боломжгүй түр лаазалсан хүнсний ногооны импорт бараг зогсжээ.

Зураг 27. Лаазалснаас бусад боловсруулсан хүнсний ногооны импорт, мянган ам.доллар




Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Харин боловсруулсан хүнсний ногооны хэрэглээг бид ҮСХ-ны ӨНЭЗС-ны анхдагч тоон мэдээллээс тооцов. Хэдийгээр дээр ашигласан импортын тоон мэдээлэл болон өрхийн түүвэр судалгааны мэдээллүүд нь өөр өөр эх сурвалжаас авсан, ангилал болон хэмжих нэгжийн хувьд ялгаатай боловч, эдгээр мэдээллээс боловсруулсан хүнсний ногооны зах зээлийн нийлүүлэлт ба эрэлтийн ерөнхий дүр зургийг авч болохоор байна. Тухайлбал, өрхийн хэрэглээний тооцооноос үзэхэд, өрхүүд хүнсэндээ ногооны лаазалсан салат, савласан өргөст хэмх, пүнтүүз зэрэг боловсруулсан хүнсний ногоог голчлон хэрэглэж байна. Мөн төрөл бүрийн мөөг, далайн байцай, вандуй, шош, дүүфүү, шар буурцаг зэрэг нарийн ногоог хагас боловсруулсан хэлбэрээр худалдан авч хэрэглэж байна. Хэрчих, хатаах, хөлдөөх, даршлах зэргээр хагас боловсруулсан дотоодын хүнсний ногоог худалдан авдаггүй, цөөн өрх л өөрийн хэрэгцээндээ зориулж хагас боловсруулалт хийдэг.

Боловсруулсан хүнсний ногооны сүүлийн жилүүдийн хэрэглээг дараах зурагт харуулав. Нийт хэрэглээг авч үзвэл, өрхүүд жилдээ 30 тэрбум орчим төгрөгийг боловсруулсан хүнсний ногоонд зарцуулж байна. 2016 онд эдийн засгийн өсөлт саарч, өрхүүдийн орлого буурсантай холбоотойгоор өрхийн боловсруулсан хүнсний ногооны хэрэглээ өмнөх онтой харьцуулахад 20% гаруй буурч байжээ.


Зураг 28. Боловсруулсан хүнсний ногооны өрхийн хэрэглээ, 2015-2017 он



Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС 2017 болон судалгааны багийн тооцоолол

Гэхдээ өрхийн энэ бүтээгдэхүүнд зарцуулж буй зардал нь сардаа хүнсний нийт зарлагын дөнгөж 0.1% -ийг эзэлж байгаа юм. Тухайлбал, 2017 онд өрхүүд сард дунджаар дөнгөж 246 төгрөгийг үүнд зарцуулжээ. Өрхийн сарын зарлагыг байршлаар тодруулбал, Улаанбаатар дахь өрхүүд энэ бүтээгдэхүүнийг их хэрэглэдэг бол хөдөөгийн болон сумын төвийн өрхүүд маш бага хэрэглэж байна. Харин түүхий хүнсний ногоотой харьцуулахад боловсруулсан бүтээгдэхүүний хэрэглээ улирлаас бага хамаардаг, түүхий ногооны хэрэглээ багатай хавар зуны улиралд бага зэрэг нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 11. Боловсруулсан хүнсний ногооны өрхийн сарын зардал, суурьшил ба улирлаар, 2017 он



Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС 2017 болон судалгааны багийн тооцоолол

Хэрэглэгчид, тэр дундаа хөдөө орон нутгийн иргэд боловсруулсан хүнсний ногоог маш бага хэрэглэж байна. Ялангуяа хэрчсэн, хатаасан, хөлдөөсөн ногоог огт хэрэглэдэггүй. Үүний гол шалтгаан нь хэрэглэгчид бэлтгэж, боловсруулсан ногоо хэрэглэж сураагүй, хэрэглэгчдийн дунд боловсруулсан хүнсний ногоо нь шим тэжээлээ алддаг, шинээрээ биш буюу удаан хадгалдаг, чанаргүй муу ногоог худалдахын тулд боловсруулдаг гэсэн ойлголт нийтлэг байдагтай холбоотой аж. Иймээс хот суурин газрын томоохон зах, дэлгүүрүүд дотоодын хүнсний ногоонд хагас боловсруулалт хийдэггүй, хагас

боловсруулсан ногоо ч бараг худалддаггүй ажээ. Тухайлбал, бидний судалгаанд хамрагдсан 18 зах, дэлгүүрийн дөнгөж 1 нь багахан хүнсний ногоо даршилж борлуулдаг бол 1 нь хонины чанасан толгой бэлтгэж борлуулахдаа бага зэрэг хэрчсэн, болгосон ногоо дагалдуулдаг байна.

Боловсруулсан хүнсний ногооны нэг гол хэрэглэгч нь нийтийн хоолны газрууд байх боломжтой. Гэхдээ хот суурин газрын томоохон ресторанууд бас боловсруулсан ногоо төдийлөн хэрэглэдэггүй, хэрэглэх сонирхол ч багатай байна. Учир нь тэдний дийлэнх нь хэрэглэгчдийн таашаалд нийцүүлэхийн тулд ногоог шинээр нь авч, өөрсдөө бэлтгэхийг чухалчилдаг бөгөөд ногоог хатаах, хөлдөөх, даршлахад чанар нь буурдаг гэж ойлгодог. Харин ногооны хальсыг арилгаж цэвэрлэн, хэрчиж, тусгайлан савласан тохиолдолд, хоол бэлтгэх цаг хэмнэх үүднээс хэрэглэх боломжтой гэж үздэг ажээ. Үүнээс гадна, боловсруулсан хүнсний ногоо худалдаж авснаас өөрсдөө түүхий ногоо авч бэлтгэвэл хямд болно гэж тэд үздэг. Тухайлбал, тэднээс дотоодод тариалсан хүнсний ногоонд ямар боловсруулалт хийвэл хэрэглэх вэ гэж асуухад, судалгаанд оролцсон 18 рестораны 6 нь хэрчсэн ногоо, 2 нь хөлдөөсөн, 1 нь даршилсан ногоо хэрэглэх сонирхолтойгоо илэрхийлжээ. Хатаасан ногоо авах сонирхлоо нэг ч ресторан илэрхийлээгүй.

Мөн ярилцлага хийсэн 7 агуулахаас нэг нь ч хагас боловсруулсан хүнсний ногоо худалдаалдаггүй, хадгалдаггүй ажээ. Тэднээс дотоодын хүнсний ногоонд ямар боловсруулалт хийвэл эрэлттэй байхыг асуухад 6 нь ямар нэг боловсруулалт хийх шаардлагагүй, хэрэглэгчид боловсруулаагүй ногоо хэрэглэхийг илүүд үздэг гэж хариулсан бол зөвхөн 1 агуулах л хэрчиж бэлтгэсэн ногоо эрэлттэй байж болох юм гэж хариулсан.

Гэхдээ аймаг сумын удирдлагуудтай ярилцахад, хүнсний ногоонд боловсруулалт хийвэл эрэлт нь нэмэгдэнэ гэж үзэж байна. Тухайлбал, ярилцлага хийсэн 4 хүний 4 нь хэрчсэн, 3 нь даршилсан, 2 нь хатаасан, 1 нь хөлдөөсөн ногоо эрэлттэй болно гэж хариулжээ. ХХААХҮЯ-ны мэргэжилтнүүдийн дүгнэснээр, дотоодод тариалж буй хүнсний ногоог ихэвчлэн давсалж хадгалдаг. Энэ нь давсны хэт хэрэглээг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй. Үүний оронд хатааж хадгалах нь илүү үр ашигтай, учир нь хадгалахад тусгай шаардлага тавигдахгүй хадгалалтын зардал багатай юм.

5. Хүнсний ногооны салбарын бодлогын тойм

5.1. Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгт хөтөлбөрүүд

Дотоодын төмс, хүнсний ногооны тариалалт, хадгалалт, нэмүү өртгийн сүлжээг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар хүнсний ногооны үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлсээр ирсэн. Тухайлбал, 1997-2012 онд “Ногоон хувьсгал” хөтөлбөрийг 2 үе шаттайгаар, 2008-2010 онд “Атрын III аян”-ыг хэрэгжүүлсний үр дүнд хүнсний ногооны тариалалтын талбайг 2 дахин, ургац хураалтыг 3 дахин нэмэгдүүлж, төмсний дотоодын хэрэгцээг 100% хүртэл, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг 52.5% хүртэл хангах түвшинд хүргэсэн. (Засгийн газрын тогтоол, 2017)

Өнөөгийн байдлаар Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого зэрэг хөгжлийн баримт бичгүүдэд хүнсний ногооны тариалалтыг дэмжих зорилтуудыг тусгаад байна. Эдгээр баримт бичигт хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх дараах гол томоохон зорилтуудыг дэвшүүлсэн байна:

- Төмс, хүнсний ногооны тариалалтад ус, эрчим хүчний зарцуулалт багатай, байгаль орчинд халгүй дуслын болон хөрсөн дороос нэвчүүлэх усалгааны дэвшилтэт технологи нэвтрүүлэх;
- Хүнсний ногооны үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах, улмаар экспортын чиг баримжаатай хөгжүүлэх;
- Үр сортын чанарыг сайжруулах замаар га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх;
- Өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот, суурины хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах.

2020 он гэхэд хүнсний ногооны хэрэгцээний 70%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, улмаар 2025 он гэхэд 100% хангах түвшинд хүртэл хөгжүүлэхээр зорьсон. Түүнчлэн, Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлого зэрэг хөтөлбөрт хүнсний ногооны тариалалтаас эцсийн хэрэглэгч хүртэлх нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, дотоодын хэрэгцээг хангах хүртэл хөгжүүлэх зорилтуудыг тусган баталжээ.

Дээрх баримт бичгүүд дэх зорилтыг бодит ажил болгох хүрээнд 2017 онд Засгийн газраас “Атрын III аян”-ы үргэлжлэл болох “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр-ийг баталж, 2018-2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус хөтөлбөрийн зорилго нь өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ жилийн турш тогтвортой хангахад оршино. Тус хөтөлбөрийн санхүүжилтийн хувьд олон улсын

байгууллага, хандивлагчдын хөнгөлөлттэй зээл, тусламж, улсын төсвийн дэмжлэг зэрэг олон төрлийн эх үүсвэртэй байхаар заажээ.

Хүснэгт 12. Төмс, хүнсний ногоо тариалалтын өнөөгийн нөхцөл байдал ба “Хүнсний ногоо” хөтөлбөрийн зорилт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2017 он)	Зорилтот түвшин (2022 он)
1	Гол нэрийн хүнсний ногооны хангамж	хувь	52	100
2	Бага тархацтай буюу нарийн ногооны хангамж	хувь	10	60
3	Хүнсний ногооны нийт ургац	мян.тн	93.5	181.5
4	Хүнсний ногооны импорт	мян.тн	60.0	36.0
5	Нэгж талбайн ургац	цн/га	112.1	142.1
6	Хүнсний ногооны нэр төрөл, сорт	тоо	31 нэр төрөл, 65 сорт	40 нэр төрөл, 90 сорт
7	Хүнсний ногооны үр үйлдвэрлэл	кг	15000	20000
8	Төл сонгино, саримсны үр	тн	9	100
9	Нутагшсан ба ирээдүйтэй сорт	тоо	65	90
10	Хүнсний ногооны механикжуулалт	хувь	38	60
11	Зоорины багтаамж	мян.тн	197.5	297.5
12	Хамгаалагдсан хөрсний ургац	тн	5.1	Жилд 11.2 мян.тн өргөст хэмх, улаан лооль, амтат чинжүү, гүзээлзгэнэ хураана
13	Өвлийн хүлэмж	га	19.1	51.1
14	Нарны халаалттай болон нийлэг хальсан хүлэмж	га	56.8	166.8
15	Усалгаатай талбайн хэмжээ	га	Дуслын усалгаа 87.8 га, бороожуулах усалгаа 670 га, гадаргын усалгаа 7583.7 га	Дуслын усалгааг 412.3 га-гаар, бороожуулах усалгааг 1830 га-гаар, гадаргын усалгааг 1300 га-гаар нэмэгдүүлнэ
16	Биологийн гаралтай ургамал хамгааллын бэлдмэл	тн	0.0	300.0
17	Эрдэс бордооны үйлдвэрлэл	тн	30 мянга	50 мянга
18	Урт болон дунд хугацааны сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо	тоо	300	2100
19	Ногоо тариалдаг өрх, аж ахуйн нэгжийн тоо	тоо	35000	43000

20	Өрхийн дундаж орлого	мян.төг	1000.0	1500.0
----	----------------------	---------	--------	--------

Эх үүсвэр: Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоол

Дараагийн нэгэн том төсөл нь **Хөдөө аж ахуйн үйлдвэр, технологийн парк (ХААҮТП)** төсөл юм. Уг төслийг Аж үйлдвэрийн яам санаачлан эхлүүлсэн. Төслийн гол зорилго нь хүнсний ногоо зэрэг хөдөө аж ахуй бүтээгдэхүүнийг боловсруулах, арьс шир, цагаан идээ, мах зэрэг бүтээгдэхүүнийг боловсруулах, нэмүү өртөг шингээх зорилготой төвлөрсөн үйлдвэр, технологийн парк байгуулж хөдөө аж ахуйн секторыг дэмжих юм. Төслийн эхэн үед гол дэд бүтцийг хөгжүүлэхээр зорьж байсан хэдий ч АҮЯ-ны бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан төсөлд зарим өөрчлөлт орсон. Одоогийн байдлаар Үндэсний хөгжлийн газар хариуцан ажиллаж байна.

Засгийн газар дээр дурдсан дөрвөн секторыг дэмжих зорилгоор сумын хөгжил, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих 200 тэрбум төгрөгийн санг үүсгэсэн. Энэхүү төслийн хүрээнд мөн жижиг дунд үйлдвэрлэгчдийг газрын түрээс, төлбөрөөс чөлөөлөх, 500 сая төгрөгийн дэд бүтцийн болон санхүүгийн дэмжлэг, машин тоног төхөөрөмж зэргийн тусламж олгосон. (JICA, 2017)

Энэ төслийн хүрээнд нутгийн удирдлага, хөгжлийн байгууллагуудын санаачилгыг дэмжин ажиллах чиглэлийг тодорхойлсон. Нутгийн удирдлага, компаниудын хүсэлтийг хүлээн авч, эхний ээлжид зорилтот 9 байршлын бүс нутгийг сонгосон. Энэхүү есөн бүс нутагт Сэлэнгэ аймгийн Мандал сум шалгарч, тус суманд 500 га хэмжээтэй үйлдвэр технологийн парк байгуулахаар төлөвлөсөн. Бид түүвэр судалгааны хүрээнд тус сумын ЗДТГ-ын ХАА-н тасгийн ажилтан Т.Болормаагаас төслийн хэрэгжилт, үйл явцыг тодруулсан. Тус сумын хувьд 450 га-д хүнсний ногоо, 600 – 700 га-д төмс тариалдаг. Нийт төмсний тариалалтын 54%, бусад хүнсний ногооны тариалалтын 17%-ийг “Агросахар”, “Мандах өргөө”, “Тултын тохой”, “Хараа чулуут”, “Хэнгэрэг чулуу”, “413-р хорих анги”, “433-р хорих анги” зэрэг 26 аж ахуйн нэгж тариалдаг. Үлдсэн хэсгийг 1200 орчим өрхүүд тариалдаг ба бараг бүх өрх хүнсний ногооны аж ахуй эрхэлж байна. ХААҮТП-ийн төслийн хүрээнд Чингис бондын хөрөнгөөр өвлийн 4 хүлэмж, зуны 11 хүлэмж нийт 15 хүлэмж, 1000 тонны багтаамжтай зоорь баригдсан. Тус байгууламжууд нь сумын ЗДТГ-ын эзэмшилд байдаг ба ЗДТГ гэрээт менежер хөлслөн үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. Тариаланчид агуулахад сард нэг тонн хүнсний ногоог 10 мянган төгрөгөөр, 8х50 хэмжээтэй хүлэмжийг нэг жилийн 700 мянган төгрөгөөр түрээслэн ашигладаг байна. 2018 онд 6 бүлгийн 10 өрхийн нийт 390 тонн байцай хадгалж, борлуулж дууссан байна. Төслийн хүрээнд бүтээн байгуулагдсан дээрх зоорь, хүлэмжүүдийн үйл ажиллагаа одоогийн байдлаар тогтвортой байна гэсэн тайлбар өгсөн.

Төсөлд хамрагдах хоёрдугаар ээлжийн бүс нутгуудаар 8 бүс нутаг сонгосон. Үүнд Булган аймгийн Сэлэнгэ сум багтсан. Ийнхүү тус суманд дунд хэмжээний үйлдвэр технологийн парк барихаар төлөвлөсөн. Булган аймгийн Сэлэнгэ сумын барихаар төлөвлөж буй үйлдвэр, технологийн паркийн ТЭЗҮ-ийн аргачлалыг хийгдсэн ба хүний нөөц, газар тариалан, мал аж ахуйн нөөц, үйлдвэрлэлийн нөхцөлүүд болон бусад хүчин

зүйлсийн тооцоо хийгдсэн. Маш дэлгэрэнгүй (500 хуудас орчим) ТЭЗҮ хийгдсэн. ТЭЗҮ хийх хүрээнд хөдөө ахуй 16 зах зээлийн судалгаа, болон бүтээгдэхүүний тариалалт, үйлдвэрлэл, логистик, дэд бүтэц, хөгжүүлэлт зэргийн төлөвлөгөө хийгдсэн. Судалгааны баг тус сумын ХХААҮТП хариуцсан мэргэжилтэнтэй уулзах хүсэлт удаа дараа гаргаж, ажлын байранд очсон боловч холбогдох мэргэжилтэн солигдсон, ажлын байран дээр байхгүй гэсэн шалтгаанаар судалгаанд оролцоогүй.

Хүнсний үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэгдсэн дараагийн нэгэн том алхам нь хүнсний ногооны гарал үүслийг тодруулах, бүртгэхэд чиглэсэн нэгэн том ажил нь 2015 онд хүнс, хөдөө аж ахуйн сайдын А-105 тушаалаар баталсан “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй журам” гэж удирдах албан тушаалтнууд үзэж байна. Тус журмаар гарал үүслийн бичиг маш нарийн, тодорхой болгох эрхзүйн орчныг бүрдүүлсэн. Зах зээлд борлуулах зорилгоор тариалсан бүх төрлийн төмс, хүнсний ногоонд заавал хувийн тариаланчийн тамгатай гарал үүслийн бичгийг сумын агрономич олгодог болсон. Мэргэжлийн хяналтын газраас хүнсний ногооны гарал үүслийн гэрчилгээг хянадаг. Энэхүү гэрчилгээнд тариалалтын бүх үе шатыг хамруулан бичдэг. ХХААХҮЯ-ны төмс хүнсний ногоо хариуцсан мэргэжилтний үнэлгээгээр энэхүү ажлын гүйцэтгэл 30%-тай байгаа аж.

Түүнчлэн, Засгийн газраас гаргасан өвлийн хүлэмжийн цахилгааны шөнийн тарифыг тэглэх шийдвэр нь тариаланчдад хүлэмжийн аж ахуй эрхлэх маш сайн хөшүүрэг болж байна.

Хөдөө аж ахуйн салбарын удирдах байгууллагын бүтэц харьцангуй сайн тогтсон гэж салбарын удирдах албан тушаалтнууд үзэж байна. 21 аймаг тус бүрд 12 мэргэжилтэн бүхий Хөдөө аж ахуйн газар байдаг. Цаашлаад сум тус бүрд хөдөө аж ахуйн асуудал хариуцсан ажилтан байна. Хөдөө орон нутагт хэрэгжиж буй хүнсний ногооны үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, дэмжих хөтөлбөрүүдийн өнөөгийн байдлыг тодруулахын тулд судалгааны баг 2 аймаг, 2 сумын хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтнүүдтэй¹ ярилцлага хийсэн. Судалгаанаас үзэхэд, тариалангийн бүс нутаг дахь сум орон, нутгийн удирдлагууд тариаланчдад зориулсан төрөл бүрийн дэмжлэг үзүүлдэг байна.

Сэлэнгэ аймаг бол төмс, хүнсний ногоо тариалалтаараа улсад тэргүүлдэг, тариалангийн гол бүс нутаг юм. 2018 онд тус аймгийн хэмжээнд 1300 тариаланч улсын нийт тариалсан төмсний 20.4%, хүнсний ногооны ургацын 37%-ийг тариалжээ. Аймгийн захиргаа 6 төрлийн хүнсний ногооны үрийг тариаланчдад үнэгүй тараадаг. Тариалан эрхлэлтийг

¹ Судалгаанд оролцогчид:

- Сэлэнгэ аймгийн Хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн үйлдвэрлэл, технологи хариуцсан ахлах мэргэжилтэн, аймгийн ерөнхий агрономич Бадарч
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЗДТГ-ын дарга Д. Байгалмаа
- Булган аймгийн Хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны дарга Б. Энхбаяр, мэргэжилтэн Н. Пүрэвсайхан
- Булган аймгийн Сэлэнгэ сумын ИТХ-ын дарга Х. Хүдэрчулуун

дэмжих сангаас мотоблог үрлэгч, сийрүүлэгч, хураах техник, 6х20 хэмжээтэй хүлэмж зэргийг 30%-ийн урьдчилгаа, 4 жилийн хугацаатай, жил бүрийн намар жилд нэг удаа төлөх нөхцөлтэй олгож байна. Энэ жил тус аймгийн Засаг даргын тамгын газар “Сэлэнгэ төмс, хүнсний ногоо” хөтөлбөр батлан хэрэгжүүлж эхэлж байна. Хөтөлбөрийн хүрээнд тариаланчдын механикжуулалтын түвшнийг дээшлүүлэх, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх, томоохон зооринууд байгуулах, дундын хоршоог дэмжих, эрэлтэд үндэслэн тариалалтын төлөвлөгөө гаргадаг болох зэрэг зорилт дэвшүүлжээ. Гэхдээ зарим зорилтыг биелүүлэхэд санхүүгийн эх үүсвэр тодорхойгүйн улмаас түр зогсонги байдалд байна. Мөн Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Монгол төмс” хөтөлбөртэй хамтран “Сэлэнгэ тав” гэх төмсний шинэ брэнд сорт гаргахаар ажиллаж байна. Цаашид хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, сонгино саримсны үйлдвэрлэлийг тэлэхэд илүү анхаарах шаардлагатай байна гэж нутгийн удирдлагууд үзэж байна.

Сэлэнгэ аймгийн Мандал суманд хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээ, үйлдвэрлэлийг дэмжихийн тулд жил бүр ногоочдын зөвлөгөөн зохион байгуулах, үрийн шинэчлэл хийх, чанарын баталгаатай үр, ургамлын хамгааллын бордоо зэргийг хөнгөлөлттэй үнээр олгох, 13 төрлийн техник, тоног төхөөрөмж, бага оврын тракторын түрээсийн үйлчилгээ үзүүлэх зэрэг дэмжлэгийг сумын удирдлагаас үзүүлж байна. 2018 онд 8 төрлийн сургалтад 350 орчим хүнсний ногоо тариаланчид хамрагдсан. Тариаланчдыг нэгдэж хоршиж ажиллахыг дэмждэг. Одоогоор тус суманд 6 хоршоо, 18 бүлэг байна. Бүлгүүд тус сумын нутаг дахь “Бороо Гоулд” алтны уурхайд 14 хоногт тутам ээлжлэн хүнсний ногоо нийлүүлж байна. “Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран 2017 онд 10, 2018 онд 12 зорилтот бүлгийн өрхөд, 10 бүлэгт хүлэмж байгуулжээ.

Булган аймагт одоогийн байдлаар 511 тариаланч төмс, лууван, манжин зэрэг хүнсний ногоог голчлон тариалж байна. Төмс, хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээг дэмжих чиглэлд Засгийн газраас баталсан “Хүнсний ногоо” хөтөлбөрийн дэд хөтөлбөр хэрэгжиж байгаа. Тус хөтөлбөрийн хүрээнд хүнсний ногооны тариалалт, хөрс хамгааллын чиглэлээр бүлэг, хоршоогоор чийгийн улаан хорхой үржүүлэх, бордоо бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж байна. Аймгийн хэмжээнд хүн амын хүнсний ногооны хэрэгцээг хангах стратеги боловсруулан ажиллаж байгаа. Тус аймгийг төлөөлсөн УИХ-ын гишүүнийн санаачилгаар “Шинэ хөдөө” хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, хөтөлбөрөө боловсруулж байна. Тус хөтөлбөр нь өрхийн тариалалтыг дэмжих, механикжуулах, усалгааны эх үүсвэрээр хангах зорилтуудыг дэвшүүлж байна.

Булган аймгийн Сэлэнгэ суманд нийт 87 тариаланч хүнсний ногоо тариалж байна. Сумын захиргаа 30 сая төгрөгөөр ногоочдын тариалангийн талбайг хашаажуулсан. Сум хөгжүүлэх сангаас тариаланчдыг бүлгийн зохион байгуулалтад оруулж, 16 иргэнд тус бүр 6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хэлтэстэй хамтарч “Өвөл суралцъя” сургалтыг зохион байгуулдаг. “Газар түшсэн амьжиргаа” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг жил бүр уламжлал болгон сумын хэмжээнд

зохион байгуулж байна. Сумын захиргаа тариаланчдаас түрээсийн төлбөр авахгүйгээр зөвхөн урсгал зардлыг гаргуулан тариалангийн трактороор хангадаг.

Бид хүнсний ногооны салбарт баримталж буй бодлогын талаар тариаланчид ямар байр суурьтай байгааг судалгааныхаа явцад тодруулсан. Судалгаанд хамрагдсан 11 тариаланчийн 5 нь Монгол ногоо хөтөлбөр, Сум хөгжүүлэх сан, Глобал коммюнити төсөл зэрэг хүнсний ногоо тариалалтыг дэмжих арга хэмжээнд хамрагдаж байжээ. Харин 3 нь иймэрхүү төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдэх боловч хамрагдаж байгаагүй бол үлдсэн 3 нь энэ талаар огт мэдэхгүй байв.

Тэд бүтээгдэхүүний үнэ цэн, борлуулалтын үнийг нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай гэж үзэж байв. Бусад арга хэмжээнд бордоогоо тохируулах, ногоондоо чанарын шинжилгээ байнга хийлгэж баталгаажуулах, дундын зуучлагчаар дамжуулалгүй өөрийн гэсэн борлуулалтын цэгээр худалдах зэргийг дурдаж байв.

Зураг 29. Бүтээгдэхүүний үнэ цэнийг дээшлүүлэхэд шаардлагатай алхам, давтамж



Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Тариаланчид Засгийн газар болон бусад байгууллагаас дараах туслалцаа дэмжлэгийг хүсэж байна.

Зураг 30. ХАА, хүнсний ногооны тариалалтыг дэмжихэд шаардлагатай зүйлс, давтамж



Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Дээрх зургаас харахад санхүүгийн дэмжлэг нэн тэргүүнд шаардлагатай байгаа бол ногооны агуулах, хүлэмж барих, тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмжийн дэмжлэг мөн чухалд тооцогдож байна.

Бид мөн энэ судалгааны хүрээнд хүнсний ногооны худалдаачид, агуулахын бизнес эрхлэгчдээс тус салбарт хэрэгжүүлэх шаардлагатай бодлого, арга хэмжээний талаар санаа бодлыг нь тодруулсан. Тэдний ихэнх нь Засгийн газрын зүгээс дотоодын хүнсний ногооны тариалалт, түгээлт, борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд тариаланчдад бага хүүтэй зээл олгох шаардлагатай гэж үзэж байна. Үүнээс гадна, агуулахын хүрэлцээг нэмэгдүүлэх, агуулах зоорь барихад дэмжлэг үзүүлэх, дотоодын ногооны импортын ногоотой өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс импортын ногооны татварыг нэмэх, импортыг хязгаарлах, дотоодын ногооны үнийг хямдруулахад анхаарал хандуулах, усжуулалтын системийг сайжруулах, эргэлтийн талбай газрын асуудлыг шийдэх, тариаланчдын ур чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах зэргээр дэмжлэг үзүүлэх боломжтой гэж үзэж байна.

Гэхдээ бодлогын тухайд нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. Хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээний бүх үе шатны оролцогчид болон бодлого боловсруулах, удирдах шатны албан тушаалтнуудтай ярилцлага хийх явцад олон төрлийн бэрхшээл, асуудлуудыг хөндөж байгаа боловч гарц шийдлийн хувьд Засгийн газар, орон нутгийн захиргааны дэмжлэгийг л онцлох хандлагатай байна. Гэвч, Засгийн газрын нөөц хязгаарлагдмал тул эдгээр санал болгож байгаа арга хэмжээнүүдийн үр нөлөөг нарийн тооцож, дэс дараатай хэрэгжүүлэх нь чухал юм.

5.2. Олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд

Одоогийн байдлаар Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ) Европын холбоо, Азийн хөгжлийн банк (АХБ) болон Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны агентлаг (ШХА) зэрэг олон улсын байгууллагуудаас газар тариалан, ойн аж ахуй болон хүнсний ногооны салбарын хөгжил, эрхзүйн орчинд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн төслүүдийг Засгийн газар болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна.

НҮБ-ын ХХААБ “Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн бодлогод дэмжлэг үзүүлэх” төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Төв Ховд, Хөвсгөл аймгуудад мах, хүнсний ногоо, цагаан идээ, арьс шир, ноос ноолуурын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн гол зорилго нь мах, сүү, арьс шир, хүнсний ногооны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ногоон хөгжлийг дэмжих замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх явдал юм.

Монгол Улсад хэрэгжүүлж буй ХХААБ-ын дараагийн нэг төсөл нь ХХААХҮЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын Органик Хөдөө Аж Ахуйг Дэмжих” төсөл юм.

Энэхүү төсөл нь органик хөдөө аж ахуйг дэмжих замаар хөдөөгийн хүн амын бизнесийг дэмжих, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх хүрээнд 3 жил орчим хугацаанд хэрэгжинэ. Төслийн хүрээнд органик үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхийн тулд техникийн болон сургалтын дэмжлэг үзүүлж байна. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн “Органик Монгол хүнс” системийг байгуулснаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн мэдээллийг онлайнаар цуглуулах боломжийг бүрдүүлж, засгийн газрын хянагч, байцаагчдыг сургалтад хамруулж, органик хүнсний гэрчилгээ олгосноор чанарын хяналтыг сайжруулах боломжоор хангаж байна.

Монгол улсын Засгийн газрын хүсэлтээр ШХА манай улсын төмс үйлдвэрлэлийн салбарт дэмжлэг үзүүлэн ажиллаж иржээ. Хамгийн анх 2004-2007 онд “Монгол төмсний үйлдвэрлэлийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд төмсний шинэ сортыг импортоор оруулж, Монголын нөхцөлд ургах, нутагших чадварыг тодорхойлсон. Тус шинэ сортууд хуучин сортуудаас илүү ганд тэсвэртэй, эрт боловсордог, нэг га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх давуу талтай байсан. Энэ мэт эерэг үр дүн гарсан тул тус төсөл үр үржүүлгийн схемийг байгуулсан. Тус төслөөс хойш хүнсний ногоо тариаланчид хуучин үрээ шинэ үрээр сольсон ба энэ нь төмсийг боломжийн үнээр худалдаж авах, цаашлаад хөдөө орон нутгийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах боломжийг бүх нийтэд олгосон. ШХА төслийн эхний үе шат дууссаны дараа буюу 2007-2015 онд “Хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих Монголын Фермерүүдийн Холбоо” төслийг мөн хэрэгжүүлсэн.

Төслийн гол зорилго нь “Хүнсний аюулгүй, шим тэжээллэг байдлыг нэмэгдүүлэх, Монголын төмсний салбарын бүтээмжийг дэмжих замаар хүн амын орлогыг дээшлүүлэх”-д хувь нэмэр оруулах байсан. Төмс тариалагчдын газрын хэмжээг тэлэх, нийлүүлэлтийн сүлжээнд оролцож буй бусад талуудыг дэмжих замаар монгол төмсний шим тэжээлийг сайжруулах, үнийг боломжийн түвшинд хүргэхэд чиглэсэн. Тус төслийн зорилтот бүлэг буюу үр ашгийг хүртэгчид нь жижиг төмс үйлдвэрлэгчид, худалдааны төмс тариалагчид, төмс, хүнсний ногооны үр үйлдвэрлэгчид болон Хөдөө аж ахуйн судалгааны хүрээлэн байсан.

Төмсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсний дараа буюу 2016 онд ШХА “Хүртээмжтэй, тогтвортой хүнсний ногооны үйлдвэрлэл, маркетинг” гэх өөр нэгэн төслийг эхлүүлсэн. Тус төсөл нь хүнсний ногоо тариаланчид (ялангуяа хөдөө орон нутаг дахь бага хэмжээний тариаланчид, хотын ядуу өрхүүд)-ын амьжиргааг хүнсний ногооны салбарын хүртээмжтэй, хүйсийн тэгш, тогтвортой өсөлтөөр дамжуулан дэмжихэд чиглэсэн. Төслийн хүрээнд 2019 оны эцэс гэхэд биелэх дараах 4 үр дүн хүлээгдэж байна:

1. Сайн сортууд, үрийн чанар, технологи болон тариаланчдын мэдлэг сайжирсны нөлөөгөөр дотоодын хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдэх;
2. Хүнсний ногооны зах зээл хөгжиж, хүртээмж сайжирснаар жижиг хүнсний ногоо тариалагчид болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн орлого нэмэгдэх;
3. Хүнсний ногоо тариалалт нэмэгдсэнээр хот, суурины амьжиргааны түвшин доогуур өрхүүдийн хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээ нэмэгдэх;

4. Хүнсний ногооны салбарын бодлогын болон хууль эрхзүйн орчин сайжрах.

Түүнчлэн, АХБ Засгийн газрын хүсэлтээр хүнсний ногооны салбарыг дэмжин ажиллаж байна. 2018 оны 3-р сард Засгийн газар АХБ-д Хүнсний ногооны үйлдвэрлэл, усалгаатай тариаланг дэмжих төсөлд зээлийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргасан. Төслийн нийт зардал нь 42.4 сая ам.доллар бөгөөд үүний 40 сая ам.долларыг хөрөнгө оруулалт, чадавхыг бэхжүүлэхэд зориулсан зээл хэлбэрээр, 2 сая ам.доллар нь олон эх үүсвэр бүхий тусламжийн хэлбэрээр, үлдсэн 0.4 сая ам.долларыг төв болон орон нутгийн захиргаа санхүүжүүлэх юм.

Энэхүү төсөл нь хоршоо, бүлгийн тариалалтын жишиг загварыг нэвтрүүлэх, тогтвортой усжуулалтын системээр хангах, нэмүү өртгийн сүлжээг дэмжих үйлчилгээ болон дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах, фермер-зах зээлийн холбоог дэмжих замаар хөдөө орон нутгийн хүн амыг ажлын байраар хангах, орлогыг нэмэгдүүлэх зорилготой. Төслийн зорилтуудыг дараах байдлаар тодорхойлжээ:

1. Усалгаатай тариалангийн системийг сэргээх, 6 хүртэлх аймагт тариаланчдын бүлэг, хоршоог хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээнд нэгтгэн, хүртээмжтэй болгох
2. Улаанбаатар хотод хүнсний ногооны зоорь, бөөний худалдаа, сав баглаа боодлын хүчин чадлыг нэмэгдүүлэх
3. Төслийн хүрээнд байгуулах усалгааны систем, өртгийн сүлжээ дэх тоног төхөөрөмж, байгууламжийн тогтвортой, хүртээмжтэй хэрэглээг хангахын тулд институтын чадавх, зохицуулалтыг бэхжүүлэх, тариаланчдын химийн бодис, бордоог зохистой ашиглах чадавхыг нэмэгдүүлэх (ж.нь, хортон шавжийн нэгдсэн менежмент, хөдөө аж ахуйн сайн туршлагыг сурталчлах гэх мэт ажлыг гүйцэтгэх)

АХБ мөн Японы ядуурлыг бууруулах сангийн санхүүжилт бүхий “Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих замаар амьжиргааг дээшлүүлэх төсөл”-ийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байна. Төсөл нь Төв аймгийн Борнуур, Орхон, Дархан-Уул, Увс аймгийн Улаангом, Сэлэнгэ аймгийн Ерөө зэрэг дөрвөн бүс нутагт жижиг хүнсний ногоо тариалагчдын амьжиргааг сайжруулах зорилготой туршилтын төсөл юм. Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд нөхөрлөлийн фермерийн загварыг нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөдөө аж ахуйн практикийг нэвтрүүлэх, тариалан-зах зээлийн харилцаа холбоог бэхжүүлэхэд анхааран ажиллана.Түүнчлэн, Борнуур, Орхон, Улаангом, Ерөө сумдад газар тариалангийн нэмүү өртгийн сүлжээнд 30 тариалан, үр үйлдвэрлэлийн бүлгийг зохион байгуулна. Төсөлд хамрагдагсдыг хүнсний ногооны үйлдвэрлэлийг тогтвортой эрхэлж байгаа эсэх, амьжиргааны түвшин, бодлогын хэрэгжүүлэх орчин байгаа эсэх, тээврийн гол сүлжээнд ойрхон байх зэргийг харгалзаж сонгох ажээ. Тус төсөл нь 2017 онд батлагдсан бөгөөд 2022 онд дуусахаар төлөвлөгдсөн байна.

Өнөөгийн байдлаар олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй газар тариалангийн салбар, ялангуяа хүнсний ногооны аж ахуйг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт тогтвортой, үр дүнтэй хэрэгжиж байна. Хэрэгжиж дууссан

төслүүдийн хувьд “Монгол төмс төсөл” шинэ сортын үрийг амжилттай нэвтрүүлж чадсанаараа төмсний үйлдвэрлэлийг тогтвортой түвшинд хүртэл нэмэгдүүлэх боломжийг олгожээ. Сүүлийн үед хэрэгжиж буй төслүүд Монголын хөдөө аж ахуйн салбарыг гүнзгийрүүлж судлан, түүнд үндэслэж нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд чиглэж байна. Мөн уг төслүүд судалгааны явцад илэрсэн дутагдалтай тал, хүндрэлүүдэд үндэслэн төсөл, хөтөлбөрийн гол зорилтот бүлгээ ихэвчлэн хүнсний ногооны салбарын хөгжил бага хөдөө орон нутгийн, жижиг тариаланчид, өрх толгойлсон эмэгтэйчүүдээр тодорхойлж, техникийн тусламж үзүүлж байна. Техникийн тусламжид хүнсний ногооны тариалалт, маркетинг, хууль эрхзүйн орчин болон дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг хүнсний ногооны аж ахуйн янз бүрийн чиглэлийн сургалт, семинар, сургалтууд багтаж байна.


6. Хүнсний ногооны салбарт тулгамдаж буй бэрхшээл

Судалгааны явцад хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талуудын дурдсан бэрхшээлтэй асуудлыг энэ бүлэгт нэгтгэн оруулав.

6.1. Хүнсний ногоо тариалалтад тулгарч буй бэрхшээл

Энэ судалгааны хүрээнд цөөн тооны буюу 11 тариаланчдыг төлөөлөл болгон сонгож, тэдэнд бизнесээ өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийнх нь талаар тодруулж ярилцсан. Тэдний дурдсан гол бэрхшээлүүдийг доорх зурагт харуулав.

Зураг 31. Тариалангийн бизнесээ өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, давтамж



Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Дээрх зурагт харуулсан бусад бэрхшээл гэдэгт тариаланчид сав, баглаа боодол, агуулах, хүлэмж дутмаг байдаг талаар дурдаж байв.

Хүлэмж, машин трактор, агуулах гэх мэт шаардлагатай тоног төхөөрөмж нь үнэтэй байдаг учраас хөнгөлөлттэй, урт хугацаатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатайг судалгаанд оролцсон бүх тариаланч дурдаж байв. Мөн шаардлага хангахуйц тоног төхөөрөмжийн олдоц муу байдгийг тариаланчдын тал орчим хувь нь дурдсан. Үүнээс гадна шинэ тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл, танилцуулга хүртээмж муутай, хүлэмж, агуулах барих газрын зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдгийг зарим тариаланч дурдаж байв.

Тариаланчдын үйлдвэрлэлийн өртөг зардалд нөлөөлдөг өөр нэг чухал хүчин зүйл бол бордоо, пестицид, тоног төхөөрөмж импортлоход ноогдуулдаг татвар, тариф юм. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дотоодын хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжихийн тулд импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодис зэргийг 2020 оны 1-р сарын 1-ний өдөр хүртэл НӨАТ-аас чөлөөлсөн.

Гэхдээ хүнсний ногооны салбарын судалгаанууд болон тариалан эрхлэгчдийн ярилцлагаас үзэхэд манай улсын хувьд хортон шавж устгах пестицид болон бордоонд 5%-ийн гаалийн албан татвар ногдуулдаг, пестицидийн хувьд зөвхөн хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон пестицид ашиглах, худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог нь бэрхшээл учруулдаг аж.

Энэ судалгааны хүрээнд бид мөн хүнсний ногоо тариалалтын чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд тулгарч буй бэрхшээлийг салбарын мэргэжилтнүүдээс тодруулсан. Үндэсний хөгжлийн газрын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын ХААҮТП төсөл хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхжаргалын өгүүлснээр, ХААҮТП төсөл өнөөдрийн байдлаар удирдах байгууллагын бүтцийн өөрчлөлт, санхүүжилтийн зогсонги байдлаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй, ХААҮТП байгуулах олон байршил сонгогдсон ч санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдэхгүй байгаа аж. Тус төслийн үйл ажиллагаануудыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлого, Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт. Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-г Архангай аймгийн Эрдэнэмандал сум, Булган аймгийн Сэлэнгэ суманд хийсэн. Гэвч санхүүжилтийн бэрхшээлээс шалтгаалан Эрдэнэмандал суманд нэг цех, Сэлэнгэ суманд мал бордох, мах боловсруулах цехүүдийг хувийн хөрөнгө оруулалтаар байгуулснаас өөр ажил хийгдээгүй.

Сум орон нутгийн удирдлагуудын зүгээс төсөл хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байгаа ч хяналт тавих удирдлагын ур чадвар дутуу, тариаланчдын механикжуулалтын түвшин маш бага тул бүтээмж муу, хүлэмж, хадгалах зориулалтын зоорь, агуулахын дутагдалтай, ногоочдын мэдлэг, зах зээлийн мэдээлэл маш хомс зэрэг хүндрэлүүдийг голчлон дурдаж байлаа. Цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг тариалангийн аргазүй, технологийн талаарх сургалтын хүрээг тэлэх, борлуулалтын системийг хөгжүүлэх, агуулах, механикжуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатайг санал болгосон. Зорилтот бүлгийг илүү тариаланчдын бүлэг, хоршоололд чиглүүлэх нь хэрэгжилтийг илүү үр дүнтэй болохыг зөвлөж байна.

Хүнсний ногооны тариалан эрхлэгчдэд тулгарч буй дээр дурдсан болон бусад бэрхшээлийг нэгтгэн дурдвал:

- Ерөнхийдөө бүтээмж багатай, зардал ихтэй боловч ургац хураалтын үеэр бүтээгдэхүүний үнэ хямдарч орлого бага олдог, тиймээс ашиг багатай, хөрөнгө оруулалтын эх үүсвэр бүрдүүлж чаддаггүй
- Ихэнх тариаланчид бага талбайд ногоо тарьдаг учир бүтээмжээ нэмэгдүүлэх зорилгоор хүчин чадал ихтэй машин, тоног төхөөрөмж худалдан авах, түрээслэх боломжгүй, зээл авахад барьцаа хөрөнгө хангалтгүй
- Үндсэн болон эргэлтийн хөрөнгөд шаардагдах санхүүжилт хязгаарлагдмал, зээлийн хүү өндөр, хөнгөлөлттэй урт хугацаатай тааламжтай зээл олдоц муутай

- Жилээс жилд хүнсний ногооны үйлдвэрлэгчийн үнэ харьцангуй тогтвортой, тэр байтугай ургац сайн жил үнэ нь буурдаг. Гэтэл бордоо, пестицид, үр, бензин шатахуун гэх мэт орцын үнэ нэмэгдэх хандлагатай байгаа
- Стандартад нийцэх агуулах, зоорины хүрэлцээ муугаас ургацаа хураасан даруйд бөөнөөр нь хямд худалддаг
- Хүнсний ногоо тариалах, хураах үед хүн хүч хязгаарлагддаг, бусад үед ажиллах хүч сул зогсдог
- Хүнсний ногоо тариалах, борлуулах, хадгалах, боловсруулах талаарх мэдлэг сул, орчин үеийн арга ажиллагааны талаар мэдээлэл муу
- Хөрөнгийн хүрэлцээ муу, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, мэдлэг мэдээлэл хомс зэрэг шалтгаанаар тохиромжтой, сайн сортын үрийг сонгож тарьж чаддаггүй
- Тариаланчид сэлгэх талбай багатай, хөрс хамгаалах, усжуулах, боловсруулах тоног төхөөрөмж дутагдалтай, хөрсний бордоо төдийлөн хэрэглэдэггүй зэрэг шалтгаанаар тариалангийн гол бүс нутгуудад хөрсний үржил шим буурах хандлагатай байгаа
- Пестицид, бордоо импортлох тусгай зөвшөөрлүүдийг БОАЖЯ, ХХААХҮЯ-наас авахад чирэгдэл ихтэй байдаг тул эдгээр орцын нийлүүлэлт хязгаарлагдмал

6.2. Агуулахын үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл

Энэ судалгааны хүрээнд агуулахын бизнес эрхлэгч 7 иргэн, аж ахуйн нэгжээс тэдэнд тулгарч буй бэрхшээлтэй асуудлын талаар ярилцаж тодруулсан. Тэдний 3 нь дотоодын хүнсний ногоо худалдан авах, борлуулахад төдийлөн бэрхшээл учирдаггүй гэж үзсэн бол 4 нь дотоодын ногооны үнэ импортынхоос өндөр, том тариаланчид НӨАТ төлдөггүй байхад жижиг аж ахуйн нэгжүүд төлдөг, зээл санхүү хязгаарлагдмал, үр сортын чанар муу, тариаланчдын технологи хоцрогдмол, агуулахын стандарт муу зэрэг бэрхшээлийг дурдаж байна.

Агуулахын бизнес эрхлэгчдийн дийлэнх нь дотоодын хүнсний ногооны түгээлт борлуулалтыг нэмэгдүүлэхэд хөнгөлөлттэй зээл, төсвийн дэмжлэг татаас шаардлагатай гэж үзсэн бол зарим нь зам, дэд бүтцийг сайжруулах, тариалангийн газар эзэмшүүлэхийг тусгайлан дэмжих, стандартын агуулах олныг барих, тариаланчдыг машин, тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай гэсэн санал дэвшүүлсэн.

Иргэдийн хүнсний ногооны хэрэглээ жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байна. Иймд дотоодын хүнсний хэрэгцээг бүрэн хангахын тулд зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, чанарын шаардлага хангасан, технологийн дэвшил бүхий орчин үеийн агуулах барих нэн шаардлагатай байна.

Манай улсад өнгөрсөн хугацаанд гурван томоохон хөтөлбөрийн хүрээнд хүнсний ногооны хадгалалт, агуулах, зоорийг хөгжүүлэх ажлууд хийгджээ. Үүнд

- 2008-2010 онд “Атрын III аян”-ы хүрээнд аж ахуйн нэгжүүдийн зоорины чанар, хүрэлцээг нэмэгдүүлэх ажил хийгдсэн
- 2010-2013 онд улсын төсвийн дэмжлэгээр иргэн, аж ахуй нэгжийн зоорь байгуулах, сэргээн засварлахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжсэн. Тус хөтөлбөр нь жижиг фермерүүд буюу иргэд, аж ахуй нэгж гэсэн хоёр гол бүлэгт чиглэсэн
- 2013-2016 онд Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд хүнсний зориулалттай зоорь (махны зоорийг оруулаад) барихад зориулж 3.8% хүүтэй, 73.1 тэрбум төгрөгийн зээлийг 25 аж ахуйн нэгжид олгожээ. Үүний үр дүнд төмс, хүнсний ногооны автомат, хагас автомат удирдлагатай, иж бүрэн механикжсан ажиллагаатай зооринууд баригдаж, зоорины багтаамж 64.5 мянган тонноор буюу 37%-аар нэмэгджээ (Монголбанк, 2016).

ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн М. Ариунболдын мэдээлснээр, эдгээр хөтөлбөр хэрэгжсэний дүнд улсын хэмжээний нийт зоорь, агуулахын багтаамж 2009 онд 89 мянган тонн байсан бол 2018 оны байдлаар 200.2 мянган тонн болж нэмэгджээ. Агуулах зоорины багтаамж ийнхүү нэмэгдсэн ч дотоодын хэрэгцээг бүрэн хангаж хүрэлцэхгүй байна. Хүчин чадлыг 300 мянган тоннд хүргэх шаардлагатай байгаа ажээ.

Дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд хуучин зоорийг сэргээн засварлах ажил нэлээд хийгдсэн. Хувиараа тариалан эрхлэгч иргэдийн хувьд ихэвчлэн энгийн, нүхэн модон тулгуур бүхий зоорийг ашигладаг. Модон тулгуур нь 5-7 жил болоод илжирч муудан хугардаг. Иймээс ийм төрлийн хуучин зоорийг сэргээн засварлах нь зардал өндөр, амархан эвдэрдэг тул үр ашиггүй байдаг. Харин шинээр зоорь барих нь илүү чанартай, үр ашигтай хөрөнгө оруулалт болно.

М. Ариунболдын үзэж буйгаар, 2017 онд Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулснаар тариаланчдад зарим төрлийн дэмжлэг үзүүлэхэд хүндрэлтэй болсон. Тухайлбал, өмнө нь зоорь, агуулахын зураг төсөл хийгдсэн аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, төсвөөс хөнгөлөлттэй зээл, тусламж үзүүлдэг байсан. Ингэхдээ зээл, тусламжид хамрагдсан аж ахуй нэгжүүдийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үе шаттайгаар үнэлж, тус үнэлгээнд үндэслэн санхүүжилтийг олгодог байжээ. Тухайлбал, төсөл, хөтөлбөрт хамрагдсан хугацаанаас хойш төлөвлөгөөт ажлынхаа 70%-ийг биелүүлсэн тохиолдолд үлдэгдэл 30%-ийг олгож, төслийн хугацаа дуусахад гүйцэтгэлийг дахин үнэлдэг байсан. Энэ төрлийн дэмжлэг нь иргэн, аж ахуйн нэгжийн идэвх оролцоог дэмжсэн үр дүнтэй механизм байсан. Цаашид төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд энэ төрлийн практикийг ашиглах нь илүү үр дүнтэй аж.


Түүний хэлснээр, Төсвийн тухай хуульд төмс, хүнсний ногооны тариалалтыг дэмжинэ гэж заасан боловч төсвийн хөрөнгө оруулалт тийм ч хүрэлцээтэй бус байдаг. Ихэвчлэн улаан буудай зэрэг стратегийн бүтээгдэхүүнд чиглэсэн. Олон улсын донор байгууллагуудын дэмжлэгтэй төсөл, хөтөлбөрүүд хэрэгждэг боловч хамрах хүрээ бага байдаг аж. Яг одоогийн байдлаар хүнсний ногооны агуулах, зооринд чиглэсэн төсвийн

дэмжлэгтэй хөтөлбөр хэрэгжээгүй байна. Зарим нэг хөтөлбөр яригдаж, судлагдаж байгаа ч хэрэгжиж эхэлсэн төсөл байхгүй байна.

6.3. Хүнсний ногооны борлуулалтад тулгарч буй бэрхшээл

Энэ судалгааны хүрээнд бид хүнсний ногоо борлуулдаг зах, супермаркетын 18 худалдаачдаас дотоодын хүнсний ногоог худалдан авахад ямар бэрхшээл тулгардгийг тодруулахад дараах бэрхшээлүүдийг дурдаж байна.

Зураг 32. Дотоодын хүнсний ногоог худалдан авахад тулгардаг нийтлэг бэрхшээл, давтамж




Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Дотоодын хүнсний ногоог зах супермаркетууд худалдан авахад хаягдал, шороо ихтэй байдаг нь хамгийн нийтлэг бэрхшээл болж байна. Мөн дотоодын хүнсний ногоо импортын бусад ногоотой харьцуулахад амархан мууддаг. Тэр дундаа сонгино, нарийн ногоо амархан мууддаг. Мөн савлагаа муутай, хүргэлт байхгүй, ногоог муу ялгадаг зэрэг нь бэрхшээл учруулдаг аж. Гэхдээ “Хүндрэл байхгүй” гэж худалдаачдын гуравны нэг нь хариулсан нь онцлог юм.

Харин худалдан авсан дотоодын ногоог цааш борлуулах үед ямар бэрхшээл тохиолддогийг дараах зурагт харуулав. Дийлэнх худалдаачид дотоодын хүнсний ногоо борлуулахад хүндрэл тохиолддоггүй гэж үзэж байгаа нь онцлог байна.

Зураг 33. Дотоодын хүнсний ногоог борлуулахад тулгардаг нийтлэг бэрхшээл, давтамж



Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019


Дотоодын хүнсний ногоог цааш зарж борлуулахад ногоог том жижгээр нь болон муудсаныг ялгах, шороо тоосноос нь цэвэрлэх зэрэгт ажиллагаа их ордог байна. Мөн зах

дээр худалдаа эрхлэхэд захын ажиллах орчин нөхцөл муу, шороо тоос ихтэй, дотоодын ногоо хадгалалт муу даадаг, амархан мууддаг, худалдан авагчид дотоодод тарьсан ногооны гарал үүсэлд итгэдэггүй зэрэг хүндрэлүүд тулгардаг. Үүнээс гадна захын удирдлага, мэргэжлийн хяналтын газрын зүгээс ногооны гарал үүслийн гэрчилгээг шаардах болсон нь бэрхшээл учруулж эхлээд байгаа аж. Учир нь ихэнх тариаланчид уг бичгийг авахад хүндрэлтэй тулгардаг, зуучлагчаас эсвэл бусад захаас хүнсний ногоо худалдан авдаг зах дээр худалдаа эрхэлдэг хүмүүст мөн хүндрэл үүсгэдэг байна. “Барс” захын хувьд хүнсний ногооны худалдаа эрхлэгчдээс өдөр бүр ногооны төрөл тус бүрд шинжилгээ хийлгэж, шинжилгээний бичиг авахыг шаарддаг ажээ.

6.4. Нийтийн хоолны салбарт тулгарч буй бэрхшээл

Судалгааны явцад нийтийн хоолны салбарын гол төлөөлөгчид болох Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын томоохон ресторануудаас тэдэнд тулгарч байгаа бэрхшээлийг тодруулсан. Тэдний хувьд дотоодын хүнсний ногоо худалдан авахад үүсдэг дараах бэрхшээлүүдийг онцолж байна.

Зураг 5. Дотоодын хүнсний ногоог худалдан авахад тулгарч буй нийтлэг хүндрэлүүд, давтамж




Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Дээрх зургаас харахад ресторанууд дотоодын хүнсний ногоог худалдан авахад тулгарч буй хамгийн нийтлэг бэрхшээл нь улирлаас шалтгаалан хүнсний ногооны олноц багасаж, үнэ хэлбэлздэг явдал юм. Дотоодын хүнсний ногоо импортын ногоотой харьцуулахад шороо, хаягдал ихтэй байдаг ба хүнсний ногоог их хэмжээгээр хэрэглэдэг ресторануудад энэ нь нэлээд зардал учруулдаг аж. Мөн хадгалалт даадаггүй амархан мууддаг, үнэтэй зэрэг нь ресторан, зочид буудлууд дотоодын хүнсний ногоог хэрэглэхэд хүндрэл учруулж байна. Ресторанууд дотоодын хүнсний ногоо худалдан авахдаа буруу хадгалагдсан, муудсан буюу нийлүүлэгчийн талаас шалтгаалсан хүндрэлтэй нийтлэг тулгардаг байна. Тэр дундаа өвлийн улиралд хадгалалт буруу хийгдэж хөлдсөн ногоо их нийлүүлэгддэг, хүнсний ногооны хүргэлтийн зориулалтын машинтай нийлүүлэгч ховор байдаг.

Мөн ресторанууд худалдан авч буй хүнсний ногооныхоо гарал үүсэлд эргэлзэх тохиолдол нэлээд байдаг ажээ.

Зураг 34. Худалдан авч буй хүнсний ногооны гарал үүслийн тодорхой байдал



Эх сурвалж: ЭЗСЭШХ-ийн түүвэр судалгаа, 2019

Дээрх зургаас харахад ресторануудын дийлэнх буюу 83% нь тэдний худалдан авч буй хүнсний ногооны гарал үүсэлд итгэлтэй байдаг бол 17% нь эргэлзэж байна.

7. Дүгнэлт, санал зөвлөмж

Судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

- Төмснөөс бусад хүнсний ногооны үйлдвэрлэл дотоодын хэрэгцээгээ бүрэн хангахгүй, зөрүүг импортоор оруулж ирж байна. Ялангуяа, навчит болон нарийн ногооны зах зээлд импортын бүтээгдэхүүн давамгайлах хандлагатай байна. Төмснөөс бусад хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэгчдийн үнэ импортын үнээс өндөр байх хандлагатай, өрсөлдөх чадвар муутай байна.
- Тариаланчдын дийлэнх нь бага талбайд цөөн нэр төрлийн хүнсний ногоог уламжлалт аргаар тариалж байна. Иймээс хүчин чадал сайтай, бүтээмж өндөртэй орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах, усжуулалтын систем нэвтрүүлэх, өвлийн болон зуны хүлэмж ашиглах, агуулах зоорь барих нь тэдний хувьд хэт үнэтэй хөрөнгө оруулалтад тооцогдож, уламжлалт арга ашигласан хэвээр үлддэг.
- Жижиг тариалан эрхлэгч ихэнх өрхүүдэд шинэ технологи, аж ахуйн менежмент, зах зээлийн мэдлэг мэдээлэл хомс байна.
- Хүнсний ногооны борлуулалт, түгээлтийн асуудал төрийн бодлогоос орхигдох хандлагатай байна. Үзэсгэлэн худалдаа зохион байгуулахаас өөрөөр борлуулалтын сүлжээг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ бага хэрэгжиж байна. Стандартын шаардлагад нийцсэн агуулах зоорины хүчин чадал дутагдалтай байна. Тариаланч өрхүүд ихэвчлэн ургацаа хураасан даруйдаа бөөнөөр, хямд үнээр дундын зуучлагчдад борлуулж, нэмэгдэл өртгөөс бага хувь хүртдэг. Хүнсний ногоог тариаланчаас хэрэглэгчид шууд хүргэх, борлуулалтын шат дамжлагыг цөөрүүлж, үйлдвэрлэгч болон хэрэглэгчийн хожоог нэмэгдүүлэхэд чиглэсэн дорвитой арга хэмжээ дутагдалтай байна.
- Өрхүүдийн хүнсний ногооны хэрэглээ стандарт түвшнээс бага байна. Ялангуяа, хөдөө орон нутгийн өрхүүд хүнсэндээ хүнсний ногоог маш бага хэрэглэж байна. Мөн өрхүүдийн хэрэглэж буй хүнсний ногооны нэр төрөл маш цөөн, төмс, лууван, сонгино, байцай гэсэн бүтээгдэхүүнээр хязгаарлагдаж байна. Харин шим тэжээл, амин дэмээр баялаг нарийн ногоо, навчит ногооны хэрэглээ маш доогуур байна. Гэхдээ нөгөө талаас, энэ бүхэн нь хүнсний ногооны зах зээлийн багтаамж цаашид нэмэгдэх асар их боломж байгааг илтгэж байна.
- Боловсруулсан ногооны хэрэглээ маш бага, өрхийн орлого нэмэгдэхийн хэрээр цаашид уг зах зээл тэлэх боломж ихтэй боловч импортоос бүрэн хараат байна. Өрхүүд болон нийтийн хоолны салбарын аль алины дунд хатаасан, хэрчсэн, хөлдөөсөн гэх мэт хагас боловсруулсан хүнсний ногооны талаарх ойлголт муу, хэрэглэх дадал, хандлага маш бага байна.
- Хэрэглэгчид, борлуулагчид худалдан авч буй хүнсний ногооныхоо гарал үүслийг чухалчилж, дотоодын хүнсний ногоог таашаадаг боловч, гарал үүсэлд нь эргэлздэг хандлага түгээмэл байна. Үүнтэй холбоотойгоор “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй журам”-ыг мөрдөж эхэлсэн боловч салбарын оролцогчид уг журмын ач холбогдол, хэрэгжилтийн талаар мэдлэг бага байна.

- Тариалан эрхлэгчдэд болон тус салбарын оролцогч талуудад зориулсан шинэ технологи, инновац, бүтээгдэхүүн, төсөл, хөтөлбөр, зах зээлийн үнэ зэргийг нэгдсэн байдлаар хүргэдэг, зуучилдаг мэдээллийн нэгдсэн систем хөгжөөгүй байна.
- Засгийн газар, орон нутгийн удирдлага, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэй олон хөтөлбөр, бодлогын арга хэмжээ хэрэгжиж байгаа хэдий ч төсөл, хөтөлбөрийн явц, үр дүн, эдийн засаг, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн судалгаа бага хийгддэг, эсвэл олон нийтэд нээлттэй биш байна.

Судалгааны баг өмнөх бүлэгт дурдсан хүндрэл бэрхшээл, дээр дурдсан дүгнэлтүүдэд үндэслэн дараах тусгай болон ерөнхий бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Авч хэрэгжүүлэх шаардлагатай тусгайлсан арга хэмжээний тухайд:

- ✓ Тариалангийн газрыг өмчлөх, ашиглах, түрээслэх, усны нөөц ашиглах, үүнийгээ хөрсний үржил шимийг хадгалахтай уялдуулах талаар хуулийн тусгай зохицуулалт бий болгох, тариалангийн газрын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбарчлах
- ✓ Газар тариалангийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, орон нутагт тогтвортой ажиллуулахад дэмжлэг үзүүлэх
- ✓ Хүнсний ногоо тариалах, пестицид ба бордоо ашиглах, газар тариалангийн тоног төхөөрөмж ашиглах, хүнсний ногоо борлуулах, хадгалах, боловсруулах талаар техник арга зүйн сургалтууд зохион байгуулах, мэдлэг мэдээллийг түгээх, сайн туршлагыг дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний давуу талыг ашиглах
- ✓ Тариаланчид бүлэг, хоршоо байгуулж тариалалт ба борлуулалтын үйл ажиллагаагаа хамтран зохион байгуулах, тариалангийн талбайгаа элдэв эрсдэлээс хамгаалах, худаг ус, хүлэмж, агуулах, том оврын машин трактор зэрэг үнэтэй хөрөнгө оруулалтыг хамтран санхүүжүүлж, ашиглах хэлбэрүүдийг урамшуулан дэмжих, сайн туршлагыг дэлгэрүүлэх
- ✓ Пестицид, бордоо импортлоход шаардагддаг тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааг хялбарчлах, гаалийн тарифаас чөлөөлөх
- ✓ Газар тариалангийн машин, тоног төхөөрөмжийн импортын НӨАТ-ын чөлөөлөлтийг урт хугацаанд үргэлжлүүлэх
- ✓ Тариалангийн гол бүс нутгийн зам, цахилгаан гэх мэт дэд бүтцийн хангамжийг сайжруулах замаар хүлэмж, агуулах, тээвэр, боловсруулах үйлдвэрлэлийн боломжийг нэмэгдүүлэх
- ✓ Нарийн ногооны тариалалтыг дэмжих замаар импортыг орлох бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж тариаланчдын ашиг орлогыг нэмэгдүүлэх, үүний тулд хүлэмж, агуулах гэх мэт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, техник арга зүйд сургахад анхаарах
- ✓ Хүнсний ногоо боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, боловсруулалт хийхэд тохиромжтой сортын буюу үйлдвэрлэлийн зориулалттай төмс, хүнсний ногооны тариалалтыг дэмжих,

- ✓ Хүнсний ногооны гарал үүслийг тодорхойлж мөрдөх үйл ажиллагааны танилцуулга, ач холбогдол, олон нийтэд сурталчлах, хамрах хүрээг тэлэх, цахим хэлбэрээр хэрэгжүүлэх.
- ✓ Хэрэглэгчдэд хагас боловсруулсан хүнсний ногооны чанар, шим тэжээл, ач холбогдлын талаар зөв ойлголт өгөх
- ✓ Хэрэглэгчдийн хүнсний ногоо хэрэглэх хандлагыг нэмэгдүүлэх, ялангуяа хөдөөгийн өрхүүдийн хүнсний ногоо хэрэглэх дадал, хандлагыг идэвхжүүлэх замаар дотоодын хүнсний ногооны зах зээлийн багтаамжийг тэлэх бодлогыг хэрэгжүүлэх. Үүний тулд, хөдөө орон нутагт хүнсний ногооны хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн агуулах, тээвэрлэлт, дэд бүтцийг дэмжих шаардлагатай. Мөн Эрүүл мэндийн яамтай хамтран хүн амын эрүүл, зөв хооллолтыг уриалж, идэвхжүүлсэн мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулах
- ✓ Стандартын шаардлага хангахуйц агуулах, зоорь барих нь зардал ихтэй хөрөнгө оруулалт тул хөнгөлөлттэй, урт хугацаатай зээл, тусламжийн хүртээмжийг энэ үйл ажиллагаа руу түлхүү чиглүүлэх
- ✓ Агуулах, зоорь барих зураг төсөл, аргачлалын талаарх сургалт, холбогдох мэдээлэл хүргэх зэрэг чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанд тариаланчдыг хамруулах
- ✓ Нэгэнт барьсан агуулах, зоорийг зохистой ашиглах, хүнсний ногоог зөв хадгалах аргачлалыг зааж сургах
- ✓ Төсвийн дэмжлэг, хөнгөлөлттэй нөхцөл бүхий төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ зорилтот бүлгээ зөв тодорхойлох
- ✓ Салбарын бизнес эрхлэгчдийг дэмжлэг, тусламжид хамруулахдаа тэгш оролцоо, шударга өрсөлдөөнийг хангах

Бодлогын ерөнхий зөвлөмж

- ✓ Тус салбарын оролцогч талуудтай хийсэн ярилцлага, бусад судалгааны мэдээллээс харахад нэмүү өртгийн сүлжээний үе шат бүрийн оролцогчид төрөөс ямар нэг байдлаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх (Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас үр тарианы аж ахуйнуудад дэмжлэг үзүүлдэгтэй адил), эсвэл өөрсдийнхөө үйл ажиллагааг дэмжих тусгай бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг хүсэх хандлагатай байна. Гэхдээ бодлогын нийлүүлэлтийн талаас харвал эдгээр хүсэлтийг бүгдийг нь биелүүлж, хэрэгжүүлэх ямар ч бололцоогүй юм. Иймээс тус салбарт хийх шаардлагатай бодлогын өөрчлөлтийг зөв тодорхойлох, зохицуулах болон дэмжлэг үзүүлэх үе шат, оролцогчдыг оновчтой олж тогтоох, бодлого зохицуулалтыг нөлөөлөл, ач холбогдлоор нь эрэмбэлэх ажлыг салбарын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор, судалгаанд суурилж зохион байгуулах хэрэгтэй.
- ✓ Үүний дараа, оновчтой тодорхойлсон бодлого, хөтөлбөрөө урт хугацаанд тууштай хэрэгжүүлэх, бодлогын залгамж чанарыг хадгалах, уг бодлого хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлага тавигдана. Засгийн газар, яамдын бүтэц өөрчлөгдөх, хэрэгжүүлж байсан бодлого, хөтөлбөрийг зогсоох, хөтөлбөрийн санхүүжилтийг нь бууруулах, царцаах, улс төрийн сонгуулийн үр дүнгээс шалтгаалж бодлого, хөтөлбөр хариуцаж байсан

мэргэжилтнүүдийг халж солих зэрэг нь хэрэгжүүлж эхэлсэн аливаа арга хэмжээ үр дүнгүй өнгөрөх том шалтгаан юм. Тухайн бодлого, хөтөлбөрт өөрчлөлт оруулах гол үндэслэл нь түүний хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, чанартай сайн судалгааны дүгнэлт байх учиртай.

Ашигласан материал

- JICA. (2017). *Хөдөө аж ахуйн салбарын суурь судалгаа*. Улаанбаатар: Япон олон улсын хамтын ажиллагааны байгууллага.
- NSO. (2016). *Agriculture Survey-2015*. National Statistics Office.
- SECiM. (2018). “Монгол Улсын ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт: үнэ цэний сүлжээтэй уялдах нь”.
- Гаалийн ерөнхий газар. (2018). *Статистик эмхэтгэл*. Монголын гааль- Статистик мэдээллийн сан:
http://customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info_st-ээс Гаргасан
- Засгийн газар . (2017). *Засгийн газрын тогтоол*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем:
<https://www.legalinfo.mn/annex/details/8024?lawid=12881>-ээс Гаргасан
- Монголбанк. (2016). “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрийн тайлан. Монголбанк.
- Үндэсний статистикийн хороо. (2018). *Газар тариалан*. Статистикийн мэдээллийн сан:
https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L10_2-ээс Гаргасан
- ҮСХ. (2016). *Хөдөө аж ахуйн түүвэр судалгаа-2015*. Үндэсний статистикийн хороо.
- ХНХСИ. (2018). *Малчдын аж байдлын судалгаа*. Улаанбаатар: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт.

Хавсралт

Түүвэр судалгаанд оролцогчдын жагсаалт

Зах, супермаркет

1. Хүслэн супермаркет , Дархан хот
2. Дархан зах, Дархан хот
3. ОУХТөв, Дархан хот
4. Буян хүнсний зах, Дархан хот
5. Ижий супермаркет, Дархан хот
6. Friendly супермаркет, Дархан хот
7. Цах маркет, Эрдэнэт хот
8. Энх төв, Эрдэнэт хот
9. Есөн-эрдэнэ зах, Эрдэнэт хот
10. Hi mart, Эрдэнэт хот
11. Ижий супермаркет, Эрдэнэт хот
12. Номин супермаркет, Эрдэнэт хот
13. Номин супермаркет, Улаанбаатар хот
14. Мастер фүүдс ХХК, Улаанбаатар хот
15. Гацуурт нэрийн барааны дэлгүүр, Улаанбаатар хот
16. Алтжин бөмбөгөр, Улаанбаатар хот
17. Меркури, Улаанбаатар хот
18. Барс зах, Улаанбаатар хот

Ресторан, зочид буудал

1. Баялаг ресторан, Эрдэнэт хот
2. Queen зочид буудал, Дархан хот
3. Хараа зочид буудал, Дархан хот
4. Comfort зочид буудал, Дархан хот
5. Gold roses ресторан, Дархан хот
6. Модерн номадс ресторан, Дархан хот
7. Тохь ресторан, Дархан хот
8. Gold зочид буудал, Эрдэнэт хот
9. Asia ресторан, Эрдэнэт хот

10. Модерн номадс ресторан, Эрдэнэт хот
11. Амарсу буудлын “Наадам” ресторан, Эрдэнэт хот
12. Жем зочид буудал , Эрдэнэт хот
13. Этүгэн зочид буудал, Улаанбаатар хот
14. Туушин зочид буудал, Улаанбаатар хот
15. Grand hill зочид буудал, Улаанбаатар хот
16. Мандах их сургуулийн ресторан, Улаанбаатар хот
17. Модерн номадс сүлжээ ресторан, Улаанбаатар хот
18. Говь компанийн ажилчдын цайны газар, Улаанбаатар хот

Агуулах

1. Гацуурт хүнс трэйд, Улаанбаатар хот
2. Барс зах, Улаанбаатар хот
3. Хувь хүн, Улаанбаатар хот
4. Булган аж ахуй, Дархан хот
5. Ногоон агуулах, Дархан хот
6. Хувь хүн, Эрдэнэт хот
7. Хувь хүн, Эрдэнэт хот

Төрийн байгууллагын төлөөлөл

1. Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Агуулах, зоорь, элеватор, үтрэмийн хангамж, ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн М. Ариунболд
2. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиглэн худалдааны салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Болор
3. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам, Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Оюунсүвд
4. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн захирал Нандинцэцэг
5. Үндэсний хөгжлийн газар, Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Мөнхжаргал
6. Сэлэнгэ аймгийн Хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн үйлдвэрлэл, технологи хариуцсан ахлах мэргэжилтэн, аймгийн ерөнхий агрономич Бадарч

7. Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЗДТГ-ын дарга Д. Байгалмаа
8. Булган аймгийн Хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны дарга Б. Энхбаяр
9. Булган аймгийн Хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны мэргэжилтэн Н. Пүрэвсайхан
10. Булган аймгийн Сэлэнгэ сумын ИТХ-ын дарга Х. Хүдэрчулуун

Тариаланчид

Булган аймгийн Сэлэнгэ сумаас 6 тариаланч:

1. Ганзүрх
2. Цэнгэлтуяа
3. Нэргүй
4. Очмаа
5. Оюунчимэг
6. Нямсүрэн

Сэлэнгэ аймгийн Мандал сумаас 5 тариаланч:

7. Энхтуяа
8. Дэжид
9. Хатанбаатар
10. Бадралхүү
11. Ганболд